

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
ХӨГЖЛИЙН ДЭД ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр, Даваа гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 51

1. *“Мэдээлэл, технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-тай холбогдох цаг үеийн асуудлаар мэдээлэл сонсох*

4 – 51

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны
04 дүгээр сарын 13-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны дарга Ч.Анар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 7 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 48 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

*Томилолттой: Л.Соронзонболд;
Тасалсан: Х.Булгантуяа.*

Нэг. “Мэдээлэл, технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-тай холбогдох цаг үеийн асуудлаар мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Хууль, эрх зүй, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Л.Нямдорж, мөн яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга Д.Батбаяр, Мэдээлэл технологийн үндэсний парк төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Ж.Золзаяа, мөн газрын Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийн хөгжлийг дэмжих хэлтсийн дарга Л.Ангараг, Захиргааны хэлтсийн дарга Г.Зулбаяр, Хөрөнгө оруулалт, төслийн хэлтсийн дарга З.Сэргэлэн, Маркетинг, борлуулалтын хэлтсийн дарга У.Бибиш, Инновац, судалгаа хөгжлийн хэлтсийн дарга Ч.Сувд, Хууль, эрх зүй, виртуал бүсийн үйл ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Т.Туяа, мэргэжилтэн Б.Бямбаа, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, мөн газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албаны ахлах мэргэжилтэн Б.Даваадорж, Digital Nexus компанийн захирал Б.Тамир, Мэдээллийн технологийн нэгдсэн холбоо “МИТА” төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал Л.Хулан, мөн байгууллагын менежер П.Нямгэрэл, Infosec Intelligence компанийн гүйцэтгэх захирал Н.Баярмагнай, Монголын программ хангамжийн нэгдсэн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, “Интерактив” компанийн захирал Г.Дашжид, “Гэрэгэ Системс” компанийн захирал Н.Энхжаргал, “OnePlaceHR Technologies” компанийн гүйцэтгэх захирал Б.Хүрэлбаатар, “One day job” компанийн захирал А.Дархан, “Artum” компанийн захирал Д.Санжсүрэн, “CarePay” компанийн захирал Т.Адьяатөмөр, өмгөөлөгч Н.Оргил, Б.Ганбаатар нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Т.Билэг-Өрнөх нар байлцав.

“Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай холбогдох цаг үеийн асуудлаарх мэдээллийг Мэдээлэл технологийн үндэсний парк төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын

захирал Ж.Золзаяа, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү, Б.Жаргалан, Ж.Золжаргал, Р.Батболд нарын тавьсан асуултад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Мэдээлэл, технологийн үндэсний парк төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Ж.Золзаяа, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албаны ахлах мэргэжилтэн Б.Даваадорж, Digital Nexus компанийн захирал Б.Тамир, Мэдээллийн технологийн нэгдсэн холбоо “МИТА” төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал Л.Хулан, Монголын программ хангамжийн нэгдсэн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, “Интерактив” компанийн захирал Г.Дашжид, “OnePlaceHR Technologies” компанийн гүйцэтгэх захирал Б.Хүрэлбаатар, “Artum” компанийн захирал Д.Санжсүрэн, “CarePay” компанийн захирал Т.Адьяатөмөр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга, Ч.Анар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай холбогдох цаг үеийн асуудлаарх мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 58 минут үргэлжилж, 7 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр 15 цаг 46 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА

Ч.АНАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр, Даваа гараг
Төрийн ордны “ҮНДСЭН ХУУЛЬ” танхим
13 цаг 48 минут

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ч.Анар: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Инновац цахим бодлогын хөгжлийн дэд хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Чинбаатарын Анар, Цэндийн Баатархүү, Ринчиндоржийн Батболд, Пүрэвжавын Ганзориг, Д.Батбаярын Жаргалан гишүүн хүрэлцэн ирснээр Инновац цахим бодлогын хөгжлийн дэд хорооны ирц 71.4 хувьтайгаар 2026 оны 04 сарын 13-ны хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Өнөөдөр дэд хорооны хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал.

Нэг.Мэдээлэл технологийн үндэсний парк төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай холбоотой цаг үеийн асуудлаар мэдээлэл сонсох асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой өөр саналтай гишүүд байна уу? Өөр санал алга байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Мэдээлэл технологийн үндэсний парк төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай холбоотой цаг үеийн асуудлаар хэлэлцэж эхэлье.

Мэдээлэл технологийн үндэсний парк IT Park-ийн үйлдвэрийн газрын захирал Жаргалсайханы Ж.Золзаяа байна уу? Тийм ээ. Хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүдийг Та бүхэнд танилцуулъя.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ байна уу? Байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албаны ахлах

мэргэжилтэн, дэд хурандаа Б.Даваадорж ирсэн байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албаны ахлах мэргэжилтэн М.Үүлэнсолонго. Ирээгүй байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албаны Дотоод хяналтын хэлтсийн дарга, хурандаа Х.Оюунболд ирсэн байна. “Эрдэнэс Монгол” компанийн Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын дарга Ц.Зоригтбат Зоригтбат ирж үү? Ирээгүй байна. “Чингис хаан Үндэсний баялгийн сангийн гүйцэтгэх захирал Б.Тэмүүлэн. Б.Тэмүүлэн байхгүй байна уу? Б.Тэмүүлэн. Байхгүй байна.

Тэгэхээр тус асуудалтай холбоотойгоор хуралдаанд оролцох ажлын хэсгийн нэрсийг дуудъя.

Ж.Золзаяа ирсэн байна. Мэдээлэл технологийн үндэсний парк Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийн хөгжлийг дэмжих хэлтсийн дарга Л.Ангараг ирсэн байна уу? Ирсэн байна. Г.Зулбаяр ирсэн байна. З.Сэргэлэн ирсэн байна. У.Бибиш ирсэн байна. Ч.Сувд ирсэн байна. Ч.Туяа ирсэн байна. Б.Бямбаа мэргэжилтэн ирсэн байна.

Салбарын төлөөлөл болсон “Дижитал нэксус” компанийн захирал Б.Тамир ирсэн байна. “МИТА” Төрийн бус байгууллагын захирал Л.Хулан ирсэн байна. менежер П.Нямгэрэл “МИТА” ирсэн байна. Инфосек Интелиженсийн гүйцэтгэх захирал Н.Баярмагнай ирсэн байна. Интерактив компанийн захирал Г.Дашжид ирсэн байна. “Гэрэгэ Системс”-ийн захирал Н.Энхжаргал ирсэн байна. “OneplaceHR technologies”-ийн захирал Б.Хүрэлбаатар ирсэн байна. “Onedayjob”-ийн захирал А.Дархан ирээгүй байна. “Artum” компанийн захирал Д.Санжсүрэн ирсэн байна. “Кэйрпэй” компанийн захирал Т.Адьяатөмөр ирсэн байна.

Хуульчдын зүгээс Н.Оргил, өмгөөлөгч Б.Ганбаатар ирсэн байна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулж дууслаа.

Цахим хөгжил, инновац харилцааны яамны Хууль эрх зүйн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Л.Нямдорж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга Д.Батбаяр ирсэн байна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулж дууслаа.

Мэдээлэл технологийн үндэсний паркийн захирал Жаргалсайханы Зулзаяа танилцуулгаа хийнэ үү.

Ажлын хэсгийн микрофоныг нээе. Ж.Золзаяа захирал индрээс танилцуулга хийе.

Ж.Золзаяа: Юуны өмнө Инновац, цахим бодлогын дэд хороог ийнхүү Мэдээллийн технологи үндэсний паркийн одоо болж буй асуудлаар хэлэлцэж байгаад туйлын их баяртай байна.

Тэгээд энд бас хүрэлцэн ирсэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон бусад хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын төлөөллүүддээ маш их баярлалаа.

Өнөөдөр энэ асуудал зөвхөн нэг ийм түрээсийн асуудал биш гэдгийг хамгийн түрүүнд урьдчилж онцолж хэлмээр байна.

Учир нь гэх юм бол Мэдээллийн технологийн үндэсний парк өөрөө энэ салбарын гол зүрх болсон гүүр байгууллага гэдэг агуулгаар өнөөдөр үйл ажиллагаагаа зогсооход хүрч байгаа энэ асуудлыг олон нийтэд аргагүй эрхэд мэдээлэл хийж, тэгээд өнөөдөр дансаа нээлгээд авсан байгаа.

Тэгэхдээ энэ бол түр зуурын асуудал учраас цаашдаа бид яах ёстой юм. Ер нь IT Park өөрөө ямар үйл ажиллагаа явуулдаг юм, ямар байх ёстой юм, яаж хөгжих ёстой юм энэ талаар ер нь Та бүхэнд бас тодорхой ойлголт мэдээллийг бас өгье гэж энэхүү презентацыг бэлдсэн. Та бүхэн дэлгэц рүү анхаарлаа хандуулна уу гэж хүсэж байна.

Уучлаарай. Энд Өргөө кино театрынхан ирсэн байгаа юм болов уу?

IT Park нь Та бүгдийн мэдэж байгаагаар мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх, зах зээл дээр гаргах, олон улсын зах зээл дээр гаргах, ер нь цаад хамгийн том зорилго бол тал нутгийн цахим хөгжлийн хурдасгуур буюу Америкаар “Цахиурын хөндий” болох ийм том зорилготой, олон залуусын хүсэл мөрөөдлийн гүүр болсон ийм байгууллага байгаа.

Анх 1972 онд Шинжлэх ухаан, техник, мэдээллийн төвөөр анх үүсгэн байгуулагдаад энэхүү барилга нь 1974 онд барилга, байгууламж маань баригдсан.

Ингэж явж байгаад 2002 онд Мэдээллийн технологийн үндэсний парк нэртэй байгаад энэ хүртэл улсаас 80 сая төгрөгийн үйл ажиллагааны санхүүжилтийг авдаг байж байгаад 2016 оноос төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болох Засгийн тогтоол гараад, үүнээс хойш улсын төсөв зогссон буюу өөрөө өөрсдийгөө санхүүжүүлдэг ийм байгууллага болсон байгаа.

Тэгээд өдийг хүртэл нэг талдаа салбарын хүний нөөцийг бэлтгэх, нөгөө талдаа технологийн гарааны бизнесүүдийг бойжуулах, тэдгээрт оффисын таатай нөхцөлийг бий болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаад миний бие 2023 онд IT Park-ийн захирлаар ирсэн байгаа.

Тэгээд энэ үед ч гэсэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам агентлагаас яам болж шилжээд анхны хуультай болсон. Энэхүү мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хууль батлагдсанаараа IT Park нь энэхүү хуулийг хэрэгжүүлэгч 11 чиг үүргийг гүйцэтгэж, мөн Мэдээллийн технологийн үйлдвэрлэл дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн ажлын алба болж 2026 оны 01 сарын 01-нээс виртуал бүсийн үйл ажиллагааг авч явах болсон.

Гэвчиг өдийг хүртэл хуулийг хэрэгжүүлэх, идэвхжүүлэх үйл ажиллагаа нь тодорхой хэмжээнд доголдолтойг явж байгааг Та бүхэн Байнгын хорооны гишүүдийн хувьд мэдэж байгаа байх.

Ингээд явж байхад манай барилга нийтдээ 9 мянган метр квадрат талбайтай байх юм гуравны нэгийг “Өргөө 2” кино театр 14 жилийн хугацаанд маш бага түрээсийн төлбөртэйгөөр 14 жил бойжсон байдаг. Бусад инкубатор компаниуд хоёрхон жил бойжоод гардаг.

Тэгтэл ганцаараа 14 жилийн хугацаанд хойд жигүүр маш бага үнэтэйгээр үйл ажиллагаа явуулж, түүнчлэн цаашаагаа төрийн өмчийг дамжуулан түрээсэлж асар их хэмжээний ашиг орлого олсон байдаг.

Тийм ч учраас бид бүхэн шүгэл үлээж олон нийтэд гаргаж, шүүхэд нэхэмжлэх гаргаад, ингээд 2025 оны 12 сарын 15 буюу саяхан 4 сарын өмнө ингээд Өргөө кино театрыг албадан чөлөөлүүлсэн байдаг ийм түүхэн замналыг туулаад явж байгаа.

Энд яах вэ, гол чиглэл үйл ажиллагааны чиглэлүүд маань байж байна. Бид бүхэн гарааны бизнесүүдийг бойжуулахаас гадна салбарын бусад бүхий л оролцогч талуудтайгаа хамтран маш олон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг болсон байгаа. ЖАЙКА олон улсын байгууллагаас авхуулаад, НҮБ, дэлхийн 50 гаруй улс орнуудтай хамтран ингээд ажилладаг. Бидний үйл ажиллагаа цар хүрээ дэлхий даяар тархан маш олон талт ажлуудыг хийж байгаа ийм жижигхэн боловч том зорилготой байгууллага байгаа юм.

Одоо яг IT Park дээр маань 40 технологийн компани байршиж байгаа. Олон улсын технологийн шалгалт, сургалтыг аваад явж байгаа. Эндээ бид салбар чиглэлийг давхцуулахгүйгээр маш олон чиглэлийн хиймэл оюун ухаан, программ хангамж, эрүүл мэнд, боловсролын салбар гээд маш олон чиглэл салбарын компаниудыг бойжуулдаг.

Яг одоогийн байдлаар төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил гээд 40 гаруй IT Park Family гээд, E-Mongolia-аас авхуулаад улсын энэ онцгой объект, Шинжлэх ухаан технологийн сан, Кибер аюулгүй байдлын зөвлөл гэх мэтчилэн энэ олон байгууллагууд байдаг.

Сая гэхэд данс хаагдахад ус, цахилгаан тасраад явж байхад зөвхөн тэнд ажиллаж байгаа энэ ажлын байрыг бий болгож байгаа 450 хүний асуудал биш E-

Mongolia-гийн одоо хэрэглэгч 2 сая хүний асуудал, энэ улсын асуудал, сервер аюулгүй байдлыг алдах ийм том эрсдэлд хүрсэн гэдгийг үүгээрээ дуулгах нь зүйтэй байх гэж ер нь бодож байна.

Тэгээд бид бүхэн одоо яг энэ хуулийнхаа хэрэгжилтийн дагуу олон улстай маш том хамтын ажиллагаануудыг хийсэн.

Бид нарын дэргэд байгаа Узбекистан, Казахстан 8-хан жилийн өмнө IT Park нь үүсэн байгуулагдсан. Монгол Улс 50 жил, 54 жилийн түүхтэй. Тэгэхэд 8 жилийн дотор бид бүхний хүсэн мөрөөддөг “Unicorn” буюу тэрбум долларын үнэлгээтэй компанийг жил дараалан гаргасан байгаа. Гэвчиг бид эдгээр улсуудын IT Park-уудтайгаа санамж бичиг байгуулаад, дотооддоо байгаа инкубатор компаниудаа тэдгээр зах зээл дээр амжилттай гаргаад улсын төсвөөс ч нэг ч мөнгө гаргахгүйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Ингээд товчхон товчхон танилцуулгуудаа ингээд явуулчихъя.

Тэгээд яагаад анх Өргөө кино театр дээр нэлээн шүгэл үлээж ингэж явсан бэ гээд эргээд харах юм бол дөнгөж 17-хон технологийн компани бойжиж байсан. Бусад нь бүгд салбарын бус компаниуд бойжиж байсан.

Тэгтэл энэ олон улсын чиг хандлагаараа тухайн IT Park нь ямарваа нэгэн архидан согтууруулах ундаа борлуулдаггүй, кино театрын үйл ажиллагаа явуулдаггүй, зөвхөн тэдгээр байгууллагуудыгаа бойжуулах зах зээл дээр гаргах, хөрөнгө оруулалт хийх ийм зорилго бүхий үйл ажиллагаа явуулж байсан учраас судлаад үзсэн чинь маш олон шударга бус, хууль бус асуудлууд гарч ирснийг энд дуулгах нь зүйтэй байх.

Ингээд бид бүхэн Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хуулийг батлуулснаараа виртуал бус үйл ажиллагааг IT Park хэрэгжүүлж авч явахаар болсон.

2024 оны 9 сарын Ерөнхий сайдын Засгийн газрын тогтоол тухайн цахим яамны сайдын багцаас энэ виртуал бүсийн үйл ажиллагааг санхүүжүүлэх тухай тогтоол байдаг боловчиг бид энэ үйлдвэрийн газар учраас цахим яам болон төрийн байгууллагуудаас төсөв, санхүү авах хууль зүйн үндэслэл байдаггүй гэдэг агуулгаараа 2 жил үйл ажиллагаа маань санхүүжилтгүй зөвхөн хүн өөрсдөө үйл ажиллагаагаа явуулж байгааг энд мэдээллийг харуулж байна.

Ингээд энэ хууль дээр бид 11 чиг үүргээрээ урьдын аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагаа өнөөдрийн үйл ажиллагааг харьцуулаад харах юм бол бараг нэг агентлагийн түвшинд хүрэхүйц үйл ажиллагааны чиг үүргийг 11 том чиг үүргүүдийг гүйцэтгээд явж байна. Ингэхдээ зөвхөн өөрсдийнх нь санхүүжилтээр явж байгаа боловч энэ нь дорвитой хуулийн хэрэгжилтийг хангаж авч явж чадахгүй байгаа. Учир нь гэх юм бол бид бүхэн өөрсдөө орлогоо

бүрдүүлэхийн тулд дийлэнх ажилчдын 70 хувь нь орлого бүрдүүлэх ажлаа хийгээд яг гол бодлогын ажлаа хийхэд боломжгүй.

Дээр нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон цахим яам хоёрт тайлан өгөх бусад үйл ажиллагаанууд дээр асар их цаг алдаж бид бүхэн яг гол үндсэн ажлуудаа явуулах дээр хүний нөөцийн хувьд хүрэлцдэггүй. Ер нь шийдвэрлэх асуудлууд гэдэг агуулгаараа бүхий л асуудлуудаа энэ дээр тавиад явчихъя гэж бодож байна.

Тэгээд одоо Өргөө кино театр “Ньютур сафарис” компани гарсан байгаа.

Тэгээд энэ гарчихлаа. Тэгээд юу гэж. Оронд нь юу хийх гэж байгаа юм гэж бодож байж магад... /минут дуусав/

Ч.Анар: Гол асуудлаа ярья. Ж.Золзаяа. 2 минут сунгаж өгье.

Ж.Золзаяа: Ер нь олон улсын жишиг парк болох гэж байгаа дэлхий нийтийн чиг хандлага ийм байгаа гээд нэлээн дэлгэрэнгүй байгаа. Үүнийг Та бүхэндээ хүргүүлчихье.

Одоо шийдвэрлэх асуудлууд гээд “Ньютур сафарис”-тай холбоотой асуудлуудаа энэ дээр тусгаад ярья.

2010 оноос хойш "Дархан Өүлэн Эх" гэдэг компани анх энэ газрыг түрээслээд, дараа нь 2012 онд “Ньютур сафарис” буюу Өргөө 2-т өгсөн.

Гэхдээ энэ 2 компани нь нэг эзэдтэй буюу одоо энэ "Дархан Өүлэн Эх" нь Дархан хотын Өргөө кино театрыг эзэмшээд үйл ажиллагаа явуулдаг. Анхнаасаа ийм зохион байгуулалттай орж ирсэн гэж хардаж байгаа.

Тэгээд 2002 оноос хойш түрээсэлж байгаад өмнөх бүх үеийн Төрийн өмчийн хорооныхон болон IT Park-ийн захирлууд бага багаар анх бол 5 мянгаар түрээсэлдэг байсан. Дараа нь 6 мянга. Үүний дараа НӨАТ төлдөггүй байсныг нь хүртэл НӨАТ төлүүлдэг болгоод жил болгон ингэж олон талт ажлын хэсэг байгуулагдаж байж Өргөө кино театртэй тэмцсэн боловч өнөөдрийг хүртэл ялсан, ялагдсан гэдэг асуудлаар явж байна.

Тэгээд 2023 онд гэрээ дууссан. Гэрээ дууссанаас хойш мэдэгдэл хүргүүлээд манай энэ салбарын алдагдсан боломжийг мэргэжлийн хүмүүсээр нь гаргуулаад, ямар түрээсийн алдагдал хүлээж байгаа юм.

Дээрээс нь бид үл хөдлөхийн хөрөнгийн албан татвар, бүх татваруудыг нь өмнөөс нь төлдөг байсан. Цааш нь бас энэ төрийн өмчийг дамжуулан түрээсэлдэг байсан. Салбарын алдагдсан боломж 11.4 тэрбум гээд бүх үндэслэлүүдээ гаргаад шүүхэд өгсөн байгаа.

Шүүхэд өгөөд 2024 оноос хойш маш олон удаа хойшлуулж, 2 жил гаруй явсны эцэст 2025 оны 3 сар, 6 сар, 10 сар гээд анхан, давах, дээд шатад нэг талдаа Өргөө кино театрыг албадан чөлөөлөх шийд гарсан боловчиг нөгөө талдаа IT Park 791 сая төгрөгийн өрөнд ороод хоёр талт шийдвэрийг гаргасан гэж үзэж байгаа.

Яагаад вэ гэх юм бол энд тогтоолоор анх Төрийн өмчийн хороо, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын байгууллага байх болохоос өмнө тэр 751 дүгээр тогтоол гэдгээр Өргөө кино театрын 5.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулсан гэдгийг хүлээн зөвшөөрсөн боловч манай дээр 5.1 тэрбум төгрөгийн хөрөнгө өнөөдрийг хүртэл ороогүй байдаг.

Шүүхийн шийдвэрээр 3.1 тэрбум төгрөгийг манайх өгөх, нөгөө талд 2.3 тэрбум төгрөгийг өгөх гэсэн. Үүний зөрүү нь 791 сая төгрөг болсон байдаг.

Тэгээд үүнийг бид 3.1 тэрбум төгрөгийн хөрөнгийг хүлээж авах юм байх гэсэн чинь ийм хөрөнгө энэ дээр үнэндээ байгаагүй. Бид 630 сая төгрөгийн хөрөнгийг сая 4 талт ажлын хэсгээр хүлээж авсан байдаг.

Ингээд манайх гарчхаад байхад эргүүлээд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар дээр эдний дансыг хаагаач ээ гээд 12 сар, сая энэ 4 сар гээд манай дансыг битүүмжилснээр манай байгууллагын үйл ажиллагаа зогсох том эрсдэлд хүрсэн. Ажилчдынхаа цалинг тавьж чадахгүй, үйл ажиллагаа явуулах боломжгүйд хүрсэн байгаа.

Тэгээд өнгөрсөн 5 дахь өдөр хэчнээн данс нээгдсэн ч гэсэн өнөөдөр энэхүү 791 сая төгрөг. Цаашдаа энэ асуудлыг шийдвэрлэхээр Хууль зүйн яаманд хандсан. Тэгээд манай энэ статусын асуудлыг ч гэсэн өнөөдөр энэ хэлэлцэх хурлаараа Та бүхэнтэй хэлэлцэхийг хүсэж байна.

Ч.Анар: Баярлалаа.

Тэгэхээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас харьяалж байгаа газрынхаа тухайн үүссэн нөхцөл байдалтай асуудлыг Төрийн өмчийн хорооноос Ц.Баяр-Эрдэнэ дарга танилцуулъя.

Ц.Баяр-Эрдэнэ дарга гол асуудлаа товч тодорхой сайн танилцуулаарай.

Ц.Баяр-Эрдэнэ: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Ингээд өнөөдрийн энэ сонсгол зохион байгуулж байгаа нь бас цаг үе болсон асуудал гэж ойлгож байна.

Ингээд би маш товчхон үндсэн мэдээллийг Та бүхэнд танилцуулъя.

Ер нь 2016 оны 12 сарын 21-ний өдрийг хүртэл бол энэ байгууллага. Дэлгэцэн дээр мэдээлэл.

Энэ байгууллага маань улсын төсөвт үйлдвэрийн газар хэлбэртэйгээ үйл ажиллагаагаа явуулж ирсэн.

Ингээд 2017 оноос үндсэндээ аж ахуйн тооцоот үйл ажиллагаа явуулж ирсэн байгууллага байгаа.

Тэгээд би Та бүхэнд нэг хавтгай дээр сүүлийн 6 жилийнх нь эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилт, түвшнийг харуулж байна. Тухайлбал –

- 2020 онд нийт орлого 910 сая төгрөг,
- 2021 онд 1.2 тэрбум,
- 2022 онд 1.6 тэрбум,
- 2023 онд 2 тэрбум орчим,
- 2024 онд 2.5,
- 2025 онд 2.5 –

-гээд ерөнхийдөө борлуулалтын орлого нь өсөөд явж байгаа.

Цэвэр ашиг, алдагдлыг харьцуулж харвал 2020 онд 120-оод сая төгрөгийн алдагдалтай байсан.

- 2021 онд балансаа бариад 2 сая төгрөгийн ашигтай.
- 2022 онд 3 сая төгрөгийн ашигтай.
- 2024 онд 82.3 сая.
- 2025 оны хувьд аудитлагдсан тайлангаар 90 орчим сая төгрөгийн ашигтай ажиллаж байгаа.

Тэгээд ажиллагсдын тоо 38-аас 42 хүн ажиллаж ирсэн.

Гол орлого олдог борлуулалтын орлогын 90 хувийг үндсэндээ байраа түрээслүүлж олдог.

Ер нь 1972 онд байгуулагдсан. Мэдээллийн технологийн гарааны компанийг бизнес инкубаторт бойжуулах, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэдээллийн технологийн шалгалт, сургалт зохион байгуулж, холбогдох төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлээд явж байгаа байгууллага байгаа юм.

Би энд энэ мэдээлэл технологийн үндэсний паркийн “Нью Тур Сафарис”-тай холбоотой асуудлыг бас товчхон дурдаад явъя. Түүрүүн захирал танилцуулсан учраас би аль болох багцлаад явъя.

2010 оноос эхлэн энэ харилцаа үүссэн. Тухайн үед Мэдээлэл технологийн үндэсний парк улсын төсөвт үйлдвэрийн газар хэлбэртэй үйл ажиллагаа явуулж байсан байгаа.

Энэ “Дархан Өлүн Эх” ХХК-тай хамтраад түрээсийн гэрээ байгуулсан байдаг. 5 жилийн хугацаатай түрээсийн гэрээ. Ямар нэг хөрөнгө оруулалт талаар тухайн үедээ яриагүй байдаг.

Энэ “Дархан Өлүн Эх”-ээс “Нью Тур Сафарис” түрээслэгчийн эрхээ шилжүүлж, барилгын жигүүрийн хойд хэсэгт үндсэндээ кино театрын зориулалтаар түрээслэх гэрээ байгуулсан. Кино театраа тухайн үед Мэдээлэл технологийн үндэсний паркийн үндсэн чиг үүрэгт нийцэж байгаа гэж тухайн үедээ талууд үзсэн байдаг.

Улмаар 2011 онд тодорхой хийсэн хөрөнгө оруулалтуудаа бид хөрөнгө оруулалт хэлбэрээр баталгаажуулах ёстой гэсэн асуудлыг тухайн үеийн Төрийн өмчийн хороонд тавиад, тэгээд хүлээн авах боломжгүй гэсэн шийдвэрийг тухайн үеийн Төрийн өмчийн хороо 2011 оны 12 сарын 22-нд гаргасан байдаг.

Харамсалтай нь Төрийн өмчийн хорооны 2012 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар энэ асуудлыг дахиж авч хэлэлцээд мэргэжлийн байгууллага тодорхой хэмжээнд үнэлээд дүгнүүлээд ороод ирвэл Төрийн өмчийн хороонд тавьж шийдвэрлүүлэхээр холбогдох шийдвэрийг гаргаад, улмаар 2015 оны 751 дүгээр тогтоолоор Хөрөнгийн үнэлгээний төв гээд хөрөнгө оруулалтын үнэлгээг нь баталгаажуулаад “Нью Тур Сафарис”-ыг 5.2 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг баталгаажуулсан шийдвэрийг гаргасан байдаг.

2016 оноос хойш энэ асуудлыг үндсэндээ өнөөдрийн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Нийслэлийн прокурор, IT Park хамтраад хууль хяналтын байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлэхээр үе шаттай арга хэмжээнүүдийг авч ажилласан.

Ингээд 2023 онд гэрээ дуусаж байсан. Гэрээг дахин сунгахгүй байх хүрээнд Цахим яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, IT Park-аас ажлын хэсэг гаргаж ажиллаад ингээд бид бол одоо гэрээг шүүх дээр хоёр талаасаа тодорхой хөрөнгө оруулалтууд, хөрөнгийн дүнгээр маргаан үүсгээд өнөөдрийн байдлаар бид 791 сая төгрөгийн мөнгөн төлбөрийг “Нью Тур Сафарис”-т төлөхөөр шүүхийн шийдвэр гарсан байгаа.

Бид энэ шүүхийн шийдвэрийг нөгөө талтай гэрээ байгуулаад тодорхой хугацаанд үе шаттай төлөх асуудлыг тавьсан. Харамсалтай нь нөгөө тал маань Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт нэхэмжлэл гаргаад данс битүүмжилсэн асуудал үүссэн.

Ер нь манай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийнхэн маань дараагийн шийдлүүд яах вэ гээд тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа гэдгийг онцолж хэлье.

Цаашид ер нь мэдээллийн технологийн салбарын гол хууль өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Судалгаа, бизнес хөгжүүлэлтийн төв болгож энэ байгууллагыг өөрчлөн зохион байгуулж орчин үеийн hub, олон улсад хэрэглэгдэж байгаа энэ бүтэц зохион байгуулалт руу оруулах ёстой юм байна гэж үзэж байгаа.

Ингээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төрийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах чиглэл дотор яг энэ агуулга туссан явж байгаа.

Улсын Их Хурал төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, нээлттэй болгох, IPO гаргах үндсэн чиглэлийг хэлэлцээд дэмжсэн. Ажлын хэсэг байгуулагдаад явж байгаа. Бид өнөөдөр үндсэндээ төсвийн эх үүсвэргүй. Өөрөө өөрийгөө санхүүжүүлэх. Гэхдээ тэр байрныхаа түрээсээр өөрийгөө санхүүжүүлэх ийм л ажлыг хийж яваа.

Тэгээд мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих энэ виртуал бүсийн үндэсний зөвлөлийнхөө ажлын албыг манай IT Park мөнүүдээр хэрэгжүүлээд явж байгаа.

Гэхдээ яг Засгийн газрын тогтоолоор бол уг нь санхүүжилтийг нь улсын төсвөөс сайдын багцаас гаргаад явахаар туссан юм байна лээ.

Гэхдээ харамсалтай нь өнөөдөр энэ шийдэгдээгүй.

Цаашид ер нь энэ төрийн өмчийн ногдол ашиг төрд төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хувиас чөлөөлөх зэрэг эдийн засгийн хөшүүргүүдийг ойрын үед зохион байгуулахаар бид газрын хурал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хурал дээр манай Төрийн болон орон нутгийн өмчийн хуулиар яг эрх зүйн хүрээндээ төрийн барилга, байгууламжийг түрээслэх юм бол 40 хувийг нь улсын төсөвт төвлөрүүлэх асуудлыг аль болох уян хатан зохицуулалт хийгээд IT Parkаа дэмжих бодлого чиглэл хэрэгжүүлээд явж байгаа гэдгийг онцолж хэлье.

Товч мэдээлэл. Яг хуулийн нарийн процесстой асуудлуудаар манай Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа ирж оролцож байгаа.

Ч.Анар: Ц.Баяр-Эрдэнэ даргад баярлалаа.

Тэгэхээр 14 жил төрийн өмчийг өртгөөс нь хямдаар шамшигдуулан ашиглаж, чиг үүргийн дагуу бус ашиглаж ирээд, тэгээд буцаагаад төрийг өрөнд оруулаад.

Тэгэхээр “Нью Тур Сафарис” буюу “Өргөө-2” компанид дэд хорооны зүгээс хүрэлцэн ирж тайлбар тавихыг албан бичгээр хүргүүлсэн. Өнөөдөр хүрэлцэж

ирээгүй байна. Тийм ээ. “Нью Тур Сафарис”-аас байна уу? Дахиад асууя. Байхгүй байгаа юм байна.

Тэгэхээр энэ асуудалтай холбогдолтойгоор дэд хорооны гишүүд асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Мөн өнөөдрийн хуралдаанд дэд хорооны гишүүн бус Улсын Их Хурлын гишүүн Дүгэрийн Рэгдэл гуай оролцож байна. Саруулсайханы Цэнгүүн бас оролцож байна.

Б.Жаргалан гишүүнээр тасалъя. Цэндийн Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Манай IT Park бол мэдээллийн технологийн салбарын гол дижитал эко систем гэдгийг бүгд ойлгож байгаа.

Тэгээд манай Ж.Золзаяа энэ түрээсийн асуудлаар шүүхэд хандаж цаг хугацааны явцад ялалт байгуулсанд баяр хүргэе.

Энэ бол зөвхөн IT Park, Өргөө кино театр хоёрын түрээсийн асуудал биш. Монголын Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын бодлогын алдааны илрэл энд харагдаж байгаа. Энэ хоёр байгууллагын асуудал биш ээ. Одоо байгаа хуулиа харах юм бол нэг нь хөрөнгө оруулалт хийсэн гээд шүүхийн шийдвэр гаргасан.

Тэгээд нөгөө талдаа шүүхийн шийдвэрээр мөнгө төлнө гэдэг асуудал юм шиг боловч цаанаа өөр асуудал яваад байгаа.

Ямар асуудал явж байна вэ гэхээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар бодлогогүй байна.

Нэгдүгээрт, Та бүхэн шууд гэрээ хийхийг нь зөвшөөрч 2012 оны 3 сард гэрээ хийлгэсэн бол гэрээ хийсэн тал Та бүхэн 791.0 сая төгрөгийг төлөх хууль, эрх зүйн боломж гаргалгаа харагдаад байгаа байхгүй юу.

Хэрвээ энэ IT Park цаашдаа засаглалын хувьд түрээсийн орлого хөөцөлдөхгүй цэвэр дижитал эко системээ хөгжүүлэх, старт апуудаа хөгжүүлэх энэ ажилдаа анхаараад явах юм бол засаглалын хувьд зөв болно.

Миний ойлгож байгаагаар үндсэн ажлаа IT Park хийхийн тулд хөрөнгө оруулалтын сан байгуулах хэрэгтэй. Чингис хаан хөрөнгө оруулалтын сангийн тодорхой хувь манай мэдээллийн технологийн салбарын сан руу ордог байх хэрэгтэй.

Бид энэ байгалийн баялгаа оюуны баялаг болгоно гэж байгаа юм бол энэ хуульд л дэд хорооныхон өөрчлөлт оруулаад өгчихье өө л гэдэг саналыг би удаа дараа хэлээд байгаа.

Улсын төсвөөр манай Ай Ти-гийн салбар бойжиж хөгжиж амжихгүй ээ. Төр, хувийн хэвшлийн түншлэл, их сургуулиудын төлөөлөл, судалгааны байгууллагуудын төлөөлөл нийлсэн Удирдах зөвлөлийг байгуулаад ингээд хараат бус мэргэжлийн байгууллага бий болгоод, дэргэдээ хөрөнгө оруулалтын сантай болох юм бол тэр сан нь өөрөө энэ уул уурхайн тодорхой хуримтлал үүсдэг энэ Чингис хаан үндэсний сантайгаа уялдаж байж жинхэнээсээ hub болж хөгжинө.

Одоо байгаа манай энэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар юу яриад байна вэ гэхээр орлогын төлөвлөгөө тавьдаг. Тэгээд өөрсдөө IT Park дур мэдэж түрээслэх гэхээр дундуур нь түрээс явуулдаг. Яаж энэ орлого чинь биелэх юм. Тэгээд үндсэн ажлаа хийхгүй. Нөгөө “Unicorn” гэдэг компаниа түрүүлэх гэхээр энэ түрээсийн орлоготойгоо хөөцөлдсөөр байгаад дуусна шүү дээ.

Тэгэхээр үндсэн ажлыг нь хийлгэх хэрэгтэй.

Тэгэхээр манай дэд хорооныхон юу ярих гээд байна вэ гэхээр IT Park бол статусын хувьд тусгай статустай хуулийн этгээд буюу Хонконгийн загварыг авах хэрэгтэй. Хонконгийн загварыг авах нь зөв болов уу гэж бодож байна. Энэ загвараар бид хуульд өөрчлөлт оруулаад бид үнэхээр дахиад Сангийн яамтай олон сайд энэ цахимын сайдууд ойлголцож чадахгүй байгаа. Виртуал бүсээ яг үндсэнд нь ажиллагаанд оруулж чадахгүй байгаа.

Тэгэхээр виртуал бүс бол ингээд төсөв хүртэл хүлээдэг биш хөрөнгө оруулалтынхаа сантай уялддаг болох юм бол манай IT Park үүнийг тойрсон эко систем, үүнийг тойрсон старт апууд чинь “Unicorn” болох боломж байна. Хөрөнгө оруулалт татах эрхийг нь нээж өгье гэдэг нэг ийм санал байгаа.

Ер нь энэ асуудал дээр хуулийн хувьд, хууль зүйн хувьд гэрээ байгуулсан гэдгээрээ тэр 791.0 сая төгрөгийг үе шаттайгаар IT Park биш Төрийн өмчийн хороо төлнө. Яагаад гэвэл энэ байшин, энэ газар, тэр эд хөрөнгө чинь Монголын төрийн өмч байхгүй юу.

Тэгэхээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар өөрсдөө төлнө гэдгийг тэр хүлээж авсан акт баримт дээрээ тулгуурлаад үе шаттай төлөх ёстой гэж бодож байна. Энэ бол IT Parkт бол хамааралгүй зүйл ээ.

Тэгээд бид бас хууль өргөн барихаар статус нь өөрчлөгдөх болов уу л гэсэн ийм байр суурьтай байна.

Тэгээд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас... /минут дуусав/

Ч.Анар: Ц.Баатархүү гишүүн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шүүхийн шийдвэртэй холбогдолтой төлбөрийг төлөх, цаашдаа энэ

бодлогын алдаануудаа хэрхэх вэ гэдэг асуулт асуулаа. Ц.Баяр-Эрдэнэ дарга хариулах уу? Индэр дээрээс.

Ц.Баяр-Эрдэнэ: 2010 оноос эхэлсэн түрээсийн харилцаа яваандаа хөрөнгө оруулалт болж хувираад, ингээд төр өөрийнхөө өмч хөрөнгийг завшуулсан асуудал үүссэн.

Энэ бол тухайн үеийн ажил албан тушаалтнууд хариуцлагагүй, сэтгэлгүй хандсаны л үр дагавар.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар энэ асуудлыг залруулахын төлөө 2016 оноос хойш тасралтгүй ажилласан. Яг 2023 онд гэрээний хугацаа дуусаж байсан учраас үйл ажиллагаа нэлээд идэвхэжсэн ийм л зүйл байгаа юм.

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжоороо хариуцагч, эзэмшигч байгууллага зохицуулалт хийж байсан тухайн үеийн Төрийн өмчийн хорооны шийдвэрүүд бас тухайн үед ажил албан тушаал эрхэлж байсан хүмүүс алдаатай шийдвэр, буруу шийдвэр гаргасан гэдэг үндэслэлээр бид Авлигатай тэмцэх газар холбогдох албан тушаалтнуудыг өгсөн байгаа.

Энэ хууль хяналтын байгууллагад шалгагдаад явж байгаа.

Ер нь эцсийн дүндээ яг энэ асуудал төрийн байгууллага буруу шийдвэр гаргасан учраас төрийн өмч хөрөнгө үнэгүйдсэн, завшигдсан, бусдад давхар түрээслүүлэх, хувийн хэвшлийнхэн ашиг орлого олох боломж бололцоо гаргасан үйл явц л гэж үзэж байгаа.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар цаашид үнэхээр Төрийн өмчийн буюу нийтийн өмчийн хууль, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн байгууллагуудын хуулийг Улсын Их Хуралд өргөн барьсан байгаа. Энэ асуудлаа энэ хүрээндээ цогцоор нь шийдэх ёстой гэж үзэж байгаа. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар төсөвт байгууллага. Агентлаг.

Тийм учраас энэ асуудалд IT Park-ийн өмнөөс мөнгө төлөх тийм эрх зүйн зохицуулалт хараахан байхгүй ээ.

Тэгээд бид үүнийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд л хамтарч шийдэх ёстой.

IT Park бид бас хамтраад төрийн буруу шийдвэрээр тодорхой хэмжээний хохирол, төлбөр гарсан тохиолдолд төр барагдуулах тэр үндсэн зарчим байна. Төрийн шийдвэр гаргахад холбогдох албан тушаалтан буруу зөрүү шийдвэр гаргаад, тэр нь хууль хяналтын байгууллагаар тогтоогдсон бол тэр хүн төлөх ёстой.

Энэ хоёр хуулийн гарцыг ашиглах ёстой гэсэн ийм л байр суурьтай байгаа.

Ч.Анар: Ц.Баатархүү гишүүн тодруулах уу? Ц.Баатархүү гишүүний микрофоныг өгье.

Ц.Баатархүү: Шүүхийн шийдвэрээр төр буруу шийдвэр удаа дараа гаргаад гаргаад шүүхийн гурван шатны эцсийн шийдвэрийн дараа төрийн байгууллага яам шууд өөрийнхөө төсөв дээр тавиад төлдөг олон жишиг байгаа шүү дээ. Хүчээр төсөв дээр тавигддаг байхгүй юу.

Тэгэхээр одоо тодотгол дээр цахим яамны баланс дээр наадах чинь бараг тусгагдах юм уу, төрийн өмчийн хорооны баланс дээр тусгагдаад шууд төлөгдөнө. Яагаад гэвэл шүүхийн шийдвэр гарсан. Энэ бол эцсийнх. 791-ийг бол төлнө.

Энэ бол Төрийн өмчийн хорооны алдаа гээд байгаа юм. Яагаад гэвэл гэрээн дээр зурсан. Цаашид Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар өөрөө өмчийнхөө менежментийг хийгээд, IT Park бол жинхэнэ энэ Ай Ти салбарыг хөгжүүлэх менежментээ хийхгүй бол Золоо захирал гээд энд идэвхтэй байгаа захирлууд чинь сүүлдээ нэг ийм түрээсийн орлого хөөцөлддөг байгууллага болно.

Олон ийм мэргэжлийн холбоодыг Та бүхэн түрээсийн орлого хөөцөлдүүлдэг. Тэгээд жил болгон нэг ийм орлого тавьдаг. Ерөөсөө энэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар ажлаа хийж чадахгүй байгаа шүү.

Ч.Анар: Үг хэллээ. Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалан: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Манай улсын хувьд мэдээлэл технологийн салбар Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбаруудын нэг гэж бид ойлгож ирсэн.

Тэгээд өнгөрсөн хугацаанд энэ салбарыг хөгжүүлэх тал дээр манай хувийн хэвшлийнхэн л их идэвх санаачилгатай ажилласан. Цаашдаа мэдээллийн технологийн салбарт илүү олон ажлын байр бий болгох, экспортын орлого бүрдүүлэх, дэлхийд гарах энэ ажлуудыг зохион байгуулах ёстой гэж харж байгаа.

Гэтэл яг энэ салбарын бодлогыг зангидаж байгаа, энэ салбарын инкубатор төв болж ирсэн. Аль 2002 оноос. Тийм ээ. Бараг 20 гаруй жилийн хугацаанд энэ салбарын инкубатор төв болж ирсэн Мэдээлэл технологийн парк нь түрээсийн орлогын араас хөөцөлддөг. Тэгээд түүгээрээ хамаг цаг заваа зарцуулдаг ийм байгууллага болсонд харамсаж байна.

Өнгөрсөн хугацаанд салбарын ч хамааралгүй ийм өөр хуулийн этгээд түрээслүүлээд, тэгээд тэрийгээ чөлөөлж ч чаддаггүй явж ирсэн байдал манай энэ төрийн өмчийн бодлого ямар байгаа гэдгийг л харуулж байна гэдэг тал дээр Ц.Баатархүү гишүүнтэй санал нэг байгаа юм.

Тэгээд миний хувьд бодлогын чиглэлээр салбарын яамнаас нь асуумаар байна.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд ер нь цаашдаа IT Park-ийн ирээдүйг хэрхэн яаж төлөвлөж байгаа вэ?

Ер нь түрээснийхээ орлогын араас л хөөцөлдөөд л ингээд л яваад байх юм уу.

Ер нь цаашид хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр танай яам ямар бодлого барьж ажиллаж байгаа вэ гэж асуумаар байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тэр 2010 онд түрээсийн гэрээ ямар үндэслэлээр яг байгуулсан юм бэ? Энэ чинь салбарын хамааралгүй байгууллагатай танай газраас салбарт огт хамааралгүй газартай гэрээ байгуулсан байна шүү дээ.

Тэгээд тухайн үед ер нь ямар албан тушаалтнууд байсан юм. Тэгээд энэ чиглэлээр сая Авлигатай тэмцэх газар хандсан гэж байна. Яг хэн хэн гэдэг албан тушаалтнуудыг Авлигатай тэмцэх газар өгсөн юм бэ гэдэг асуудал байна.

Тэгээд шүүхийн процесс явж байгаа гэж ойлгож байна. Энэ анхан шатны шүүхийн шийдвэр л гарсан байгаад байгаа гэж ойлгож байгаа. Зөв үү? Дээд шатны шүүхийн шийдвэрээр таслагдсан юм уу. Тийм ээ?

Тэгэх юм бол одоо жишээлэх юм бол энэ 790.0 сая төгрөгийн төлбөрийг яах аргагүй тухайн үеийн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нэгэнт хариуцсан юм бол төсөвт хэрхэн яаж суулгах юм гэдэг тал дээр ажиллах шаардлагатай болсон юм байна шүү дээ.

Тэгээд тэр тал дээр ер нь Сангийн яамтайгаа ярилцсан юм байгаа юм уу? Ер нь энэ асуудал дээр Засгийн газрын түвшинд ямар шийдвэрүүд гараад явж байгаа юм бэ гэдэг дээр холбогдох байгууллагууд нь хариулж өгнө үү гэж хүсэж байна.

Тэгээд компаниудын төлөөлөл ирсэн байна. Та бүхэн ер нь энэ асуудал дээр ямар байр суурьтай байгаа юм бэ? Ер нь яг яаж харж байгаа юм бэ гэдэг санал бодлыг нь сонсьё.

Ч.Анар: Асуулт хариулт явсны дараагаар төрийн бус байгууллагууд болон компанийн төлөөллүүдээс санал сонсьё.

Цахим яамнаас хариулах уу? Тийм ээ. Та нэр, албан тушаалаа хэлээд асуултад хариулъя. Түүний дараагаар Төрийн өмчийн хороо, тэгээд аж ахуйн нэгжүүд асуулт асуусны дараа.

Д.Батбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга Д.Батбаяр.

Б.Жаргалан гишүүний асуултад хариулъя.

Мэдээлэл технологийн үндэсний парк бол манай салбарын эко систем гэж ярих юм бол нэг маш том бүрэлдэхүүн хэсэг нь байгаа.

Ер нь мэдээж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар харьяалагддаг боловч бодлогын хүрээнд бид хамтарч ажилладаг. Ойрын хугацаанд хийгдэж байгаа ажил гэвэл “Grok AI” компанитай хамтарсан санамж бичгийн хүрээнд 60 мянган төрийн албан хаагчидтай холбоотой хиймэл оюуны чиглэлээрх сургалтыг хийх чиглэлээр Мэдээлэл технологийн үндэсний паркттайгаа хамтраад ажиллаж байна.

Мөн “Ухаалаг засаг” гээд Дэлхийн банкны санхүүжилттэй хэрэгжиж байгаа төслийн хүрээнд “online gig jobs” гэдэг төсөл мөн манай дээр төслийн сонгон шалгаруулалтад явахаар бэлтгэл ажил хангагдаж байна.

Энэ хүрээнд мөн Мэдээлэл технологийн үндэсний паркттайгаа хамтраад ажиллана гэсэн тийм төлөвлөгөөтэй. Ашиглагч байгууллага нь Мэдээлэл технологийн үндэсний парк байна гээд ордог.

Мөн виртуал бүстэй холбоотой Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хүрээнд мөн яаман дээр бодлогын дэмжлэг үзүүлж, холбогдох журам, дүрмийг нь батлах дээр хамтраад ажиллаж байдаг.

Цаашид бид ямархуу бодлогоор явах вэ гээд.

Нэгдүгээрт, мэдээж Улсын Их Хуралд өргөн баригдсан байгаа. Нөгөө төрийн өмчийг хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах гэдэг жагсаалтад Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Мэдээлэл технологийн үндэсний паркийн статусыг өөрчлөх талаар туссан байгаа.

Улсын Их Хурлын тогтоолын төсөл Улсын Их Хурлын тогтоол маань батлагдаад гараад ирвэл бид Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон бусад холбогдох байгууллагуудтай хамтраад энэ статусынх нь асуудал дээр нэлээн ажил хийх юм.

- ▷ **Нэдүгээрт нь**, бидний хувилбарууд янз янзаар яригдаж байгаа. Цэвэр Мэдээлэл технологийн үндэсний парк байх боломжтой юу гэдэг асуудал.
- ▷ **Хоёрдугаарт нь**, одоогийн статусаа хадгалаад явбал үйл ажиллагааг нь өргөжүүлээд ингээд явах боломжтой юу.
- ▷ **Гуравдугаарт нь**, улсын төсөвт үйлдвэрийн газар болгоод цэвэр улсын төсвөөр санхүүжүүлэгдээд явах боломжтой юу.

Бүр цаашаа “Улаанбаатар хотын хөгжлийн корпорац” гэдэг шиг “Мэдээлэл технологийн корпорац” байгуулах боломж байгаа юу, байхгүй юу. Тийм ээ.

Иймэрхүү чиглэлээр бид судалгаагаа хийгээд IT Park-ийнхантайгаа хамтраад ажиллаж байгаа. Баярлалаа.

Ч.Анар: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Б.Жаргалан гишүүний асуултад хариулъя.

Ц.Баяр-Эрдэнэ: Эхний асуулт. Бид гурван шатны шүүхээр тогтоогдсон шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд хоёр хувилбар байгаа. Нэг нь парк маань өөрөө төлөх.

Гэхдээ би түрүүн үзүүлсэн. Ер нь нэлээн урт хугацааны тийм график гаргаад л төлөхгүй бол бололцоо их муу байгаа.

Тэгээд Хууль зүйн яаман дээр төрийн буруу шийдвэрээс тодорхой хэмжээнд хохирол барагдуулдаг тэр зохицуулалт руу оруулахаар Хууль зүйн сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраар дамжуулаад манай IT Park бид ажиллаж байгаа.

Тэр улсын төсөв дээр суувал энэ асуудлыг нь шийдээд явах бололцоотой юм билээ.

Хоёр дахь асуудал. Хуучин Та бүхэн харсан байх. 2015 оны тэр хөрөнгө оруулалтыг баталгаажуулах шийдвэр гарч байх үед Төрийн өмчийн хороо гэдэг байгууллага татан буугдаж байсан. Тухайн үед ажиллаж байсан Төрийн өмчийн хорооны нэр бүхий албан тушаалтнуудын шийдвэрээр хөрөнгө оруулалтыг баталгаажуулсан байдаг юм билээ.

Бид Нийслэлийн прокуророос энэ асуудлыг шүүх тавьж байх үед Авлигатай тэмцэх газарт асуудал тавьж байсан. Зүгээр яг хууль хяналтын байгууллага дээр яаж шийдэгдэж байгааг нь би нарийн сайн мэдэхгүй байна.

Тухайн үед төрийн өмчийн хорооны даргаар н.Нанзаддорж гэж хүн ажиллаж байсан байдаг юм билээ.

Ч.Анар: Б.Жаргалан гишүүн тодруулах уу? Б.Жаргалан гишүүн тодруулъя.

Б.Жаргалан: Ер нь маш товчхон дүгнэж хэлэхэд энэ IT Park дээр үүсээд байгаа асуудал юу вэ гэхээр салбарын бодлоготой огт хамааралгүй компанид 10 гаруй жил зах зээлийн үнээс маш доогуур үнэлгээтэйгээр талбай түрээслээд, эргээд төр өөрөө өрөнд орсон явдал байна шүү дээ.

Тэгэхээр үүнийг бид маш том кэйс болгож цааш цаашдын бодлогодоо тусгаж ажиллах нь чухал гэж харж байгаа юм.

Тэгэхээр би салбарын байгууллагуудын бодлыг сонсох гээд байгаа нь ер нь цаашдаа ямар бүтэц, зохион байгуулалттай ажиллах юм бол? Энэ 20 гаруй жил үйл ажиллагаа явуулсан байгууллага үндсэн голдиролдоо орох вэ гэдэг асуудал.

Түүнээс биш яамдын болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тайлбарыг тайлбарыг сонсоод байхад тодорхой шийдэл хэлж чадахгүй байна шүү дээ. Ингэвэл ингэж болно. Хоёр, гурван хувилбар бий гээд.

Тэгээд би Та бүхнээсээ юу гэж хүсэх гээд байна вэ гэхээр энэ дээр яг нөгөө экосистемийнх нь оролцогч нар нь маш идэвх санаачилгатай, иргэд, аж ахуйн нэгжүүд нь маш их идэвх санаачилгатай ажиллах ёстой байхгүй юу. Тэгж байж бид энэ зөв голдирол руу нь магадгүй шахах боломжтой л гэж харж байна. Баярлалаа.

Ч.Анар: Үг хэллээ. Гишүүд асуулт асууж дууссаны дараа хувийн хэвшил болон төрийн бус байгууллагуудын саналыг сонсоно.

Р.Батболд гишүүний микрофоныг өгье. Р.Батболд гишүүн асуулт асууна.

Р.Батболд: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Би товчхон хоёр, гуравхан л юм асууя. Тэр 5.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн л гээд байгаа юм байна шүү дээ. Ер нь.

Тэгээд тэрийг бодвол хоёр талдаа хөрөнгө оруулалтдаа тусгаад IT Park ч юм уу ингээд төлнө гэсэн нэг гэрээ байдаг байлгүй. Байдаг юм уу, байдаггүй юм уу? Байдаг болоод тэрийг үндэслэл болгоод аваад байгаа байх. Тийм ээ?

Тэгэхээр энэ дээр гэрээг хэн хэн хийсэн юм гэдгийг хэлээд өгмөөр байна.

Эргүүлээд нөгөө 3 тэрбумын үл хөдлөх хөрөнгө үлдэж байгаа гэснээсээ та хэд чинь хүлээж авч байгаа юм 603 сая л байгаа юм байна шүү дээ.

Тэгээд яах вэ, үүнийгээ буцаагаад шүүхдэх арга байдаг юм уу, үгүй юу? Одоо нэхэмжлэгчээ солиод гэсэн үг шүү дээ. Сангийн яамтай яриад Төрийн

өмчийн хороо руу үүнийг төлөх болбол та нар чинь өөрөө хариуцагч болоод явна л гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр нэхэмжлэгчээ солиод эргүүлээд шүүхэд өгөх боломж нь байдаг юм уу гэдэг.

Тэгээд тэр яг 2 мянган квадратыг бага үнээр, бага үнээр гээд байх юм. Яг хэдэн төгрөгөөр түрээслээд байсан юм? Тэрийгээ хэлж өгөөч ээ л гэсэн гурван асуулт байна лээ.

Ч.Анар: Хэн хариулах вэ? Р.Батболд гишүүний асуултад.

Эхлээд Үндэсний паркийн захирал Ж.Золзаяа, дараад нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хариулъя.

Ж.Золзаяа: Асуултад хариулъя.

Нэгдүгээрт, 5.1 тэрбум төгрөгийг Төрийн өмчийн хороо урьд нь татан буугдахаасаа өмнө тогтоол гаргаж “баталгаажуулсугай” гэсэн болохоос биш хөрөнгийг IT Park дээр “бүртгээрэй” гэсэн өгүүлбэр байдаггүй.

Тийм учраас манай дээр өдийг хүртэл нэг ч төгрөгийн “хөрөнгө оруулалт” гэсэн байдлаар 5.1 тэрбум төгрөгийн хөрөнгө бүртгэгдээгүй.

Шүүхийн шийдвэр гараад тэр 5.1-ээс нь салгаж болох 2 тэрбум төгрөгийн хөрөнгийг нь хасаад 3.1 дээр нь 2015 оны хөрөнгийн үнэлэгээ компани болон тэр 751 дүгээр тогтоолыг үндэслээд гаргасан нь өнөөдрийн 11 жилийн дараах элэгдэл, хорогдол яг тэр 3.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий хөрөнгө огт байгаагүй.

Өнөөдрийг хүртэл манай дээр ямар ч хөрөнгө бүртгэгдээгүй.

Үнэ хямд гээд байгаа асуудал нь манай жирийн Ай Ти компаниуд, бойжигчид маань, инкубаторт бойжиж байгаа компаниуд маань 2022 оны юугаар бид 1 метр квадрат нь 38 мянга 500 төгрөгөөр түрээсэлдэг байсан.

Өнөөдөр тог, ус, цахилгаан нэмэгдсэнтэй холбогдуулаад 2025 оноос авхуулаад 49 мянга 500 болж хувирсан. Хотын төвийн “Эй” зэрэглэлийн энэ бүс дээр.

Өргөө кино театр анх метр квадрат нь 5 мянгаар түрээсэлж байсан. Дараа нь 6 мянга болсон. Дараа нь В1 болон 1, 2 давхар интервалаар үзвэл 7 мянган төгрөгөөр түрээсэлсэн.

Гэвч энэ нэг компани 7 мянгаар. Нөгөө талд нь жирийн “старт ап” эхлэх гэж байгаа, бизнесээ эхлэх гэж байгаа залуучууд нь 38 мянга 500-гаар түрээсэлж байсан ялгаатай тэгш бус ийм юу гарч байсан гэдгийг энэ дээр хэлье.

Ч.Анар: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга. Та нэр, албан тушаалаа хэлээрэй.

Д.Дэлгэрмаа: Сайн байцгаана уу? Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа байна. Гишүүний асуусан асуултад хариулъя.

Төрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн асуудлыг Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор түрээсийн журмыг зохицуулсан байдаг.

Энэ журмаар төрийн өмчийн эзэмшигч нь өөрт эзэмшүүлсэн эд хөрөнгийг түрээсээр ашиглана гэсэн ийм журамтай.

Тэгээд түрээсийн доод хэмжээг Сангийн яамтай зөвшилцөж, Төрийн өмчийн хороо буюу төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага доод хэмжээг нь батлаад явдаг. Түүнээс дээшээ эзэмшигч этгээд өөрөө үнэлээд сонгон шалгаруулалтаа явуулаад түрээсийн сонгон шалгаруулалтыг хийдэг.

Түрээсийн гэрээг түрээслэгч, түрээслүүлэгч, тэгээд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага. Ингээд гуравласан гэрээ хийгээд явдаг.

Тэгээд 2010 онд IT Park энэ хөрөнгөө түрээсэлье гэж санал тавьж, энэ түрээсийн гэрээг гуравласан гэрээгээр байгуулсан байдаг.

Гурван шатын шүүх IT Park 791.0 сая төгрөг ингээд хохиролд “Нью Тур Сафарис”-т гаргаж өгөхөөр шийдвэрлэсэн.

Тэгээд бидний шүүхийн шийдвэрт хэдийгээр сэтгэл дундуур байгаа хэдий ч шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр. Гурван шатны шүүхийн шийдвэр гарсан учраас.

Энэ маргаан дээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, түрээслэгч байгууллага IT Park-аа дэмжиж, нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн дэмжиж шүүх хуралдаанд гуравдагч этгээдээр оролцож явсан байгаа.

Тэгэхээр хариуцагч биш учраас шүүхийн шийдвэр дээр юу гэж тусгасан тэр дагуу шийдвэр гүйцэтгэлийн байгууллага шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хийгээд явж байгаа.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас IT Park-ийн... /минут дуусав/

Ч.Анар: Индрийн микрофонд 2 минут нэмье.

Д.Дэлгэрмаа: Баярлалаа. Дэмжлэг үзүүлж энэ хохирлыг хэрхэн барагдуулах талаар Хууль зүйн сайдын багцад суулгаж өгөөч ээ. Хохирол барагдуулах талаас нь дэмжиж өгөөч ээ гэдэг энэ дэмжлэгийн албан бичгүүдийг удаа дараа хүргүүлсэн байгаа.

Манай байгууллага түрүүн хэлсэн. Адилхан төсвийн байгууллага. Өөр зардал тусгагддаггүй.

Тийм учраас Хууль зүйн сайдын багцаас гаргуулахаар манай байгууллага дэмжиж ажиллаж байгаа.

Шинээр нэхэмжлэл гаргаж болохгүй юу гэж түрүүн асуусан.

Тэгэхээр шүүхийн нотолгооны зарчмаар шүүхэд нэгэнт үйл баримтыг нотолсон, хэлэлцсэн бол дахиж шүүх хүлээж авахгүй байх. Хууль зүйн тийм гаргалгаатай.

Ч.Анар: Миний хувьд хэдэн асуулт байна.

Нэгдүгээрт, сая паркийн зүгээс танилцуулж байна даа.

2002 онд би өөрөө анх гарааны бизнесээ Мэдээлэл технологийн үндэсний паркаас эхэлсэн.

Тэр үед 5 мянга, 6 мянга гэдэг үнэ ч байгаагүй. Яг салбарын компани, гарааны компани байсан боловч 12 мянган төгрөг төлдөг байсан.

Гэтэл 14 жил ийм хөнгөлөлттэй үнээр чиг үүргийн биш гэрээг хийгээд, 14 жил яваад, төрийн өмчийг шамшигдуулаад, буцаагаад төрийг шүүхэд өгөөд, өрөнд оруулаад.

Энэ маш ойлгомжтой ашиг сонирхлын зөрчилтэй хэлэлцээр байна шүү дээ. Тийм ээ. Тэгээд Төрийн өмчийн хороо энд хаана юу хийж байсан юм? Төрийн өмчийн хороо хариуцсан ажилдаа төрийн өмчийг ингэж шамшигдуулах эрхийг нь хэн яагаад, хэзээ олгосон гэдэг нь он, сар, өдөр судартайгаа байгаа юм биш үү.

Яагаад төр өмчөө хамгаалах, Монгол Улсын өмчийг хамгаалах дээр ажиллаагүй юм бэ?

Дахиад энэ болсон шүүхийн процесс дээр надад явцын мэдээлэл байнга байсан. Нэг ч хөрөнгө оруулалттай ямар ч түрээслүүлэгч одоо та нар харж байгаа.

Хэн нэгний байранд засвар хийж хөрөнгө оруулалт хийж, өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглагчдад, тэрийгээ хөрөнгө оруулалтад тооцдог жишиг

дэлхийн хаана ч байхгүй. Төрийг нь бодоод шүүхийн шийдвэр гаргасан байгаа нь маш харамсалтай.

Тэгээд энэ шүүхийн шийдвэр дээр IT Park төлөөлж явсан юм уу? Төрийн өмчийн хороо явсан юм уу?

Төрийн өмчийн хороог би энэ дээр эс үйлдэхүй, идэвхгүй байдал гаргасан байна гэж харж байна.

Энэ сонирхлын зөрчилтэй 14 жил явуулсан хэлэлцээрүүдийг хийсэн, шийдвэр гаргасан хүмүүсээ Авлигатай тэмцэх газар өгсөн юм уу? Хэн өгөх ёстой юм бэ? Төрийн өмчийн хорооноос бүтэн хариулт авмаар байна. Бид мэдэхгүй гэдэг хариулт сонсмооргүй байна.

Хоёрдугаарт, сая болсон шүүхийн гурван шатын шийдвэр. Бодлого хэрэгжих, асуудал шийдэхдээ хэдэн жилээр яваад төр өөрөө асуудалд ороод байхад тэр доор нь шүүхийн шийдвэр нь арга хэмжээ авдаг. Дэмжлэг болохоороо хэдэн жилээрээ байхгүй. Тэгээд үүн дээр Төрийн өмчийн хорооноос юм уу, IT Park хэн нь энэ төрийн өмчийг хамгаалж шүүх дээр хамгаалах ёстой байсан юм? Энэ асуулт дээр IT Park болон Төрийн өмчийн хорооноос хариулт авъя.

Тэгээд одоо яамнаас хариулаад байна л даа. Цахим яам. Цахим яам энэ дээр хариуцагч яг одоогоор хууль эрх зүйн хувьд бас мөн үү? Тэр хариултыг албан ёсоор би протоколд хөтлүүлж авмаар байна.

Тэгээд дахиад тодруулна. Төрийн өмчийн хороо.

Д.Дэлгэрмаа: Д.Дэлгэрмаа байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын идэвхгүй үйлдэл байсан юм уу гэж асууж байх шиг байна. Түрүүнд би тайлбарлаж хэлсэн. Эзэмшигч байгууллага өөрөө эд хөрөнгөө эзэмшиж ашиглана гэдэг ийм зохицуулалттай.

Тэгээд төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал тухайн үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдана, шүүхэд итгэмжлэлгүйгээр төлөөлнө гэсэн хуулийн зохицуулалт байдаг.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар бол зохицуулалтын чиг үүрэгтэй. Жилд төрийн өмчит хуулийн этгээдийн 2000 гаруй түрээсийн гэрээ байгуулдаг.

Тэгээд энэ бүх түрээсийн гэрээн дээр маргаан үүслээ гэхэд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар биш эзэмшигч байгууллага түрээстэй холбоотой маргаан дээр шүүхэд төлөөлөөд нэхэмжлэлээ гаргаад явдаг.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар удирдлага, зохион байгуулалтаар, энэ асуудал дээр ч гэсэн бүрэн хангаж хамтарч ажилласан. Үйлдвэрийн газартайгаа. Маш олон удаагийн хоёр талын уулзалтуудыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар дээр тооцоо нийлье, уулзалт хийе, түрээсийн гэрээгээ байгуулъя гэдэг ийм санал, санаачилгуудыг бүрэн гаргаж явж байсныг үйлдвэрийн газрынх тайлбарлаж хэлэх байх гэж бодож байна.

Тэгээд энэ шүүхийн маргаан дээр нэхэмжлэгчийг бүрэн дэмжиж гуравдагч этгээдээр оролцож явсан юм.

Түрүүн хэлсэнчлэн шүүхийн шийдвэр бол бидний санаанд хүрээгүй. Мөн таны хэлж байгаагаар үнэхээр төрд хохиролтой. Өмч хөрөнгөө ашиглуулсныхаа илүү өр төлбөртэй шийдвэрлүүлсэн нь маш их сэтгэл дундуур үлдсэн.

Тэгэхдээ бид хэд энэ шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа дээр тодорхой шат дараалалтайгаар хуваарь гаргаж төлөх боломжтой гэж шийдвэр гүйцэтгэлийн байгууллагад хандаж тайлбарлаж хэлж байгаа.

Авлигатай тэмцэх газарт тухайн үед өгч шалгуулж байсан.

Тэгэхдээ өнөөдрийн байдлаар хэрэг үүсгэсэн талаар мэдээлэл байхгүй. Тухайн үеийн хөрөнгө оруулалтыг хэрхэн яаж хүлээн зөвшөөрсөн гэдэг асуудлаар бид шүүх дээр ч гэсэн бас маргасан байгаа. Хөрөнгө оруулалтын хэмжээн дээр.

Харин сая шийдвэр гүйцэтгэлийн явцад хөрөнгийг хүлээж авахад үнэхээр тэр оруулсан хөрөнгө оруулалт байгаагүй. Байсныгаа бүр зарим нэгийг нь салгаж дахиж ашиглах боломжгүйгээр үлдээсэн ийм асуудлууд байгаа.

Тэгэхээр харин тэр асуудал дээр харин шүүхдээд дахиад шүүхийн шийдвэрээр эдий төгрөгийн хөрөнгө оруулалтыг хүлээн зөвшөөрсөн бол бид эдий төгрөгийн хөрөнгийг хүлээж авсан. Үлдсэнийгээ бид гаргуулж авъя гэдэг байдлаар харин IT Park дахиад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хоёр зөрүүн дээр нь нэхэмжлээд явах бүрэн боломжтой гэж харж байна.

Ж.Золжаргал: Манай байгууллага 2015 оны тогтоолтой холбоотой АТГ-д гомдол гаргаж байсан.

Тэгээд тухайн үеийн албан хаагч хүмүүсээс асуусан боловч хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан гээд Авлигатай тэмцэх газар дээр энэ хэрэг нь хаагдсан байдаг. Хамгийн гол нь шүүх Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болохоос өмнөх хорооны эрх бүхий албан тушаалтнуудын гаргасан тогтоолыг үндэслэж энэ шүүхийн шийдвэр гаргасан нь өнөөдөр маш өрөөсгөл байгаа гэж үзэж байгаа.

Тэгээд цаашид бид бүхэн яг өнөөдрийн байдлаар “Нью Трюс Сафарис”-ыг дахиад шүүхэд нэхэмжлэх гаргахаар бэлдсэн байгаа. Энэ нь юу юу байгаа вэ

гэхээр саяын Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэлснээс гадна шүүхийн процесс явж байх хугацаанд 3-аас 4 газар дахин дамжуулан түрээсэлж ашиг олсон байгаа. Шүүхийн процесс явж байх хугацаанд.

Мөн түүнчлэн 2022 оны 12 сарын 31-нд түрээсийн гэрээ дууссан байхад яг үндсэн үнээр түрээсээ төлөөгүй хуучин 7 мянгаараа түрээсэлж байсан бол бид зөрүү түрээсийн төлбөр дээрээ 1.6 тэрбум төгрөгийг нэхэмжлэх гэж байгаа. Энэ мэдээллийг Та бүхэндээ бас өгье гэж бодож байна.

Ч.Анар: Р.Батболд гишүүн тодруулга асууна. Түүний дараагаар микрофон дээр Д.Рэгдэл гишүүн асуулт асуухаар байна. Б.Тулга гишүүнийг бас асуулт асуух дээр нэмье.

Р.Батболд: Асуулт гэхээсээ илүү зүгээр нэг санал Төрийн өмчийн хороонд л хэлэх гээд байгаа юм.

Яах вэ, эзэмшигч байгууллага өөрөө шийддэг гээд хаячхаад баймааргүй байгаа юм л даа. Та нар өөрсдөө нөгөө орлогын төлөвлөгөө энэ тэр гээд бүгдийг нь авч л байгаа шүү дээ. Түрээсийн орлогоор хэдэн төгрөг олоод байгаа юм, яах ёстой юм гээд.

Тэгэхээр яах вэ, энэ урд хүмүүсийн хийсэн алдаа л байх л даа.

Тэгээд та нар өөрсдөө хийгээгүй учраас хуулиараа яриад өөрсдийгөө хамгаалахаас өөр аргагүй.

Тэгэхдээ яах вэ, зүгээр жоохон сэтгэлтэй ажиллаад, Та нар дээр тэртээ тэртэй тэргүй төлөвлөгөө чинь ирж байгаа. Хэнд хэдэн төгрөгөөр яаж түр хүслэх юм, юу гэж төлөвлөсөн юм гэдэг төлөвлөгөөнүүд нь ирж л байгаа шүү дээ. Тэрийг нэг сайн ажиглаад хараад ажиллаарай л гэж хэлэх гээд байгаа юм.

Ч.Анар: Санал хэллээ. Д.Рэгдэл гишүүн.

Д.Рэгдэл: Асуулт ч асуух юм алга даа. Зүгээр санал хэлье гэж бодсон юм.

Энэ асуудлын хамгийн гол буруутан нь тодорхой л юм шиг байна. Тийм ээ. Энэ Төрийн өмчийн хороо. Яагаад тийм сонирхлын зөрчилтэй гэрээ байгуулав?

Тэгэхээр энэ сонирхлын зөрчилтэй гэрээ байгуулсны бурууг өнөөдөр тэр үйл ажиллагааг нь өвлөж авч яваа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хариуцаж л явна шүү дээ. Угаасаа төрийн байгууллага ч тэгж явдаг.

Зүгээр энд тэр нэг төрийн өмчийн байрыг түрээсэлж авчхаад засвар хийж байгаад асар их үнэтэй засвар болгоод, сүүлд нь тэр байраа өөрийн өмч болгоод авдаг процесс манайд нэлээн олон жил явагдсан. Түүний сүүлчийн нэг тохиолдол бол энэ байгаа юм.

Ингэж байгаад л асар үнэтэй болохоор төр тэрнийг нь төлж чаддаггүй. Тэгээд тэр газрын өмч болоод үлддэг. Одоо Соёлын төв өргөөний хойд тал аягүй бол шийдэгдээгүй явж байгаа. Энэ бол нэг л компаниас явж байгаа үйл ажиллагаа гэж би ойлгоод байгаа юм.

Зүгээр одоо нэгэнт шүүхийн шийдвэр гараад энэ 791.0 сая төгрөгийн өр тавьсан бол үүнийг аль нэг яамны, аль нэг улсын төсөв дээр тавьж байгаад төлөх хуулийн боломж байхгүй шүү дээ. Тийм ээ. Энэ бол өр болсон.

Зүгээр тэр өрийн хэмжээг одоо тэр 5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн гэж байгаа. Сүүлдээ 3 тэрбум болгодог энэ тэр шийдвэрийг гаргасан, тэрийг нь тогтоож өгсөн Төрийн өмчийн хороо бас л буруу шийдвэр гаргасан байгаа юм л даа. Яагаад гэвэл тэр 3 тэрбумын өмч танай паркт дээр шууд бүртгэгдэх ёстой шүү дээ. Тэгтэл одоо хүртэл бүртгэгдсэн хийсэн юм байхгүй яваад байна гэдэг чинь тэнд эзэнгүй хий өмч байж байна. Хаана ч байхгүй.

Тийм учраас энэ дээр шүүхийн шийдвэр биелүүлэхээс аргагүй.

Тэгэхдээ улсын төсвөөс биелүүлнэ гэдэг бол хэцүү гэдэг нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал нь, IT Park одоо төрийн өмчит үйлдвэрийн газар юм байна шүү дээ. Тийм ээ. Төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэг статусаас нь болиулна гэдэг санааг миний хувьд их дэмжиж байгаа. Энэ бол улсын төсөвт байгууллага болоод, улсын төсөвт байгууллагын ажилладаг зарчмаараа яваад байвал Монгол Улсад бодитой хувь нэмэр оруулах. Ерөнхийдөө их идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг л байгууллага л даа. Би бас мэдээллийг нь сонсоод л байдаг юм.

Одоо Монголд “старт ап” юм уу, эсвэл харьцангуй дэвшилтэт технологийг бойжуулдаг төрийн өмчийн байгууллага бол үндсэндээ эднийхээс өөр байхгүй. Тэр үүргээ чадах хэмжээгээр хийгээд яваад байдаг юм байна гэж ойлгодог. Тэр үйл ажиллагааг нь цааш нь үргэлжлүүлэх гол зам бол төрийн өмчит үйлдвэрийн газраа болиулаад статусыг нь төрийн байгууллага руу аваачих. Төсөвт байгууллага руу аваачиж ажиллавал их сайн.

Зүгээр энэ 791.0 саяыг угаас төлнө.

Тэгэхдээ тэр хөрөнгийг өөртөө аваагүй. Энэ парк төлөх юм уу. Эсвэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар ямар нэгэн эх сурвалж олж үүнийг гүйцэлдүүлэх юм уу. Үүнийг миний хувьд мэдэхгүй байна.

Тийм учраас Ж.Золжаргал захирал боломжоороо хөөцөлдөж энэ статусаа өөрчлөх талын юмаа ойрын үед хийвэл зүгээр байх.

Одоо танай дансууд нээлттэй байгаа гэж ойлгож байгаа. Тийм ээ. Одоохондоо. Тэгээд үйл ажиллагаагаа явуулаад тэр хооронд статусаа өөрчлөөд, тэр хооронд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар төлбөр барагдуулах асуудлыг бас нэг аятайхан шийдэх арга зам хайсан нь л дээр байх.

2027 оны төсөвт Цахим яаман дээр ч юм уу тавина гэдэг угаасаа бүтэхгүй шүү дээ.

Тэгээд үүгээр байгууллагын өр төлнө гэвэл энэ чинь хуулийн эсрэг юм болно. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар гаргалгаа гаргаж чадвал... /минут дуусав/

Ч.Анар: Д.Рэгдэл гишүүн санал хэллээ. Баярлалаа.

Б.Тулга гишүүн асуулт асууя.

Б.Тулга: Та бүгдийнхээ энэ өдрийн амар амгаланг эрье.

Би Инновацын байнгын хороонд байж байгаад Байнгын хороо шилжээд одоо зүгээр гишүүний хувиар асууж байгаа гэж Та бүхэн ойлгоорой. Дэд хорооны гишүүн биш. Их Хурлын гишүүний хувиар.

Өнөөдөр Инновацын байнгын хороонд энэ IT Park асуудлаа тавиад сонсгол хийж байгаа нь нэгдүгээрт аргаа барсан л хэлбэр л дээ. Түүнээс уг нь энэ чинь өмчийн маргаан. Тийм ээ. Өөрөөр хэлбэл төрийн өмчийн байрны маргааны асуудал юм байгаа юм шүү дээ.

Тэгэхээр гол фокус бл уг нь энэ байран дээр явах ёстой юм.

Тэгэхээр манай дэд хороо бол энэ байр, өмчийн маргааныг зохих Хууль зүйн байнгын хороо байна уу, нөгөө Байнгын хороо руу албан ёсоор хүсэлт тавьж үүнийг нэлээн нухацтай авч үзэх ёстой.

Өнөөдөр төрийн өмчийг эрх мэдлээрээ дамжуулж, танил талаараа дамжуулж зувчуулдаг, авдаг энэ процессын л нэг жишээ. Энэ бол цэвэр.

IT Park Ж.Золзаяа. Тийм ээ. IT Park-ийн захирал сүүлийн хэдэн жил шүүхдэв. Миний л мэдэхийн хоёр, гурван жил лав өнгөрсөн байх. Тийм ээ. Нэлээн олон жил шүүхдэж байгаа.

Тэгээд шат шатын шүүхийн шийдвэр гардаг. Тэгэнгүүт зөрүүлээд нөгөө нөхдүүд ажиллаж байгаад явдаг. Энэ бол нөгөө л хууль шүүхийн байгууллагад нөлөө бүхий этгээдүүд төрийн, ард түмний өмчийг үнэгүйдүүлж өөрийн болгодог энэ процессын сонгодог жишээ.

Тийм учраас үүнийг Хууль зүйн байнгын хороо байна уу, бусад Байнгын хороогоор авч үзэж энэ жишээнүүдийг олон нийтийн анхааралд хүрэх ёстой. Түүнээс IT Park-ийн хөгжлийг жичдээ бид тусад нь ярих ёстой. Энэ бол цэвэр өмчийн маргаан байхгүй юу.

Тэгээд IT Park Монгол Улс хамгийн түрүүнд анхаарал тавьж байх ёстой байгууллагынхаа үйл ажиллагааг нь хаадаг, зогсоодог ийм балай л нөхцөл байдал хэдүүлээ явж байна.

Байнгын хороон даргаас асууж байгаа нь өнөөдөр яг ямар шийдвэр гаргах гээд энэ хурлыг нэгдүгээрт. Ямар үр дүн гарах гэж байна гэдгийг Та нэг тайлбарлаж хэлж өгвөл их сайн байна. Нэг.

Тэгээд мэдээж шүүхийн шийдвэр гарсан. Нөгөө л иргэдийн яриад байдаг шүүх мөнгөтэй хүний талд үйлчилдэг, хүчтэй бүлэглэлийн талд үйлчилдэг гэдэг энэ шийдвэрүүдийн л сонгодог жишээ гэж дахин үүнийг хэлэх гээд байгаа юм.

Тэгээд энэ хариуцагчаар орж ирж байгаа гэдэг юм уу, тайлбарлаж байгаа нь IT Park байгаа юу? Тийм ээ. Энэ компани шүү дээ. Сафари ямар тур билээ? Энэ ХХК-ийн эцсийн өмчлөгч нь хэн юм бэ? Тэрийг нэг албан ёсны протоколд хэлээд өгөөч. Хэнтэй зодолдоод байгаа билээ? Та бүхэн ер нь. Хоёр асуулт. Протокол үйлдэх ёстой гэж би бодоод байна.

Ч.Анар: Б.Тулга гишүүний эхний асуултад хариулъя.

Санал нэг байгаа юм. Энэ бол ерөөсөө мөсөн уулын орой.

Тэгэхээр өнөөдөр дэд хороон дээр юу хэлж байгаа юм бэ гэхээр дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд Их Хурлын тухай хуулийн 27.2 буюу дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд судалгаа хийх, холбогдох мэдээлэл авах, зөвхөн албан тушаалтны иргэн, байгууллагаас тайлбар авах энэ зүйл, заалтын дагуу мэдээлэл авч байна.

Асуудал дээр, шүүхийн шийдвэр дээр Их Хурлын зүгээс нөлөөлөх бололцоогүй. Тантай санал нэг байна.

Зүгээр одоо энэ салбарын асуудлыг цааш нь, энэ гажуудал цаашид дахиж яаж үүсэхгүй байх вэ. Асуудлыг бид хөрсөн дээрээ бууж яаж бодитой мэдэх вэ гэдэг үүднээс салбарын төлөөлөл болон төрийн бус байгууллага, IT Park үүнийг дуудаж мэдээлэл сонсож байгаа болно. Тантай санал нэг байна.

Индрийн микрофон дээрээс хариуцагч Ж.Золзаяа Б.Тулга гишүүний асуултад хариулъя.

Ж.Золзаяа: Б.Тулга гишүүний асуултад хариулъя.

Ер нь санал нийлж байгаа. Бүгд ил хэлж чадахгүй байгаа ч гэсэн цаана нь нэг хүн л зохицуулж байгаа. Энэ бол эцсийн өмчлөгч Ц.Анандбазар. “Сод Монгол” компани.

Ч.Анар: Б.Тулга гишүүн тодруулъя. О.Батнайрамдал гишүүн асуулт асууя. Микрофон өгье.

Б.Тулга: Би тодруулъя. Тийм ээ. Сонсголд гэхээр хоёр талаас ирэх ёстой. Дэд хорооны зүгээс нөгөө компани талд урилга хүргүүлсэн юм байна. Тийм ээ?

Тэгээд Их Хурлын Байнгын хороо, Монголын ард түмний төлөөлөл Улсын Их Хурлын парламентын засаглалын, бүтцийн байгууллага. Монгол Улсын ямар ч аж ахуйн нэгж, төрийн байгууллагыг дуудах эрх, үүрэгтэй гэж би бодож байна.

Тэгэхээр ирээгүй тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэдэг юм? Албадан авчруулах янз янзын юм байна уу? Тэр манай хуулийнханд тайлбарлаач. Тэгээд бид энд л ингээд л гомдоллоод суугаад байдаг, суугаад байдаг. Нэг том толгойтой компани ирдэг ч үгүй, тайлбардаг ч үгүй томроод суугаад байж болдог юм уу? Ямар хариуцлага хүлээх вэ?

Ч.Анар: Хууль зүйн үндсээр төрийн байгууллага, албан тушаалтан заавал ирэх үүрэгтэй. Ирээгүй тохиолдолд албадан авчирдаг юм байна. Хувийн хэвшилд бол тийм үүрэг хүлээгээгүй байдаг юм байна. Хууль зүйн тайлбар нь. Хувийн хэвшилд тийм үүрэг хүлээгээгүй байдаг юм байна.

Б.Тулга гишүүний энэ асуултыг яг хууль зүйн үндсээр тайлбарыг нь аваад бичгээр хүргүүлээд, үүнийг зайлшгүй тодруулах шаардлагатай юм байна.

Албан бичгийг хүргэсэн боловч ирэхээр нэрээ өгсөн боловч ирээгүй байгаа. Түүрүүн дурдсан. “Нью Тур Сафарис” гэдэг компанитай холбогдолтой саяын протоколд Ж.Золзаяа захирлын хэлсэн энэ асуудал ганц IT Park биш. Бид бүхэн мэдэж байгаа. Монголын ард түмэн бүгдээрээ мэдэж байгаа асуудал.

Тэгэхээр энэ яалт ч үгүй дараа дараагийн асуудлуудын эхлэлийг тавьж байна.

О.Батнайрамдал гишүүн асуултаа асууя.

О.Батнайрамдал: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Энэ асуудлыг Ж.Золзаяа захирал нэлээн олон удаа хэвлэлээр ярьсан даа. Бараг мэдэхгүй хүн байхгүй болсон байх.

Тэгэхээр явсаар байгаад дахиад л өмчийн маргаан дээр л очиж байгаа юм л даа.

Тэгэхээр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бүр том зургаараа өмчийн тухай хууль яг Улсын Их Хурал дээр ажлын хэсэг гарсан. Ажиллаж байгаа юм билээ. Иймэрхүү маргаан сүүлийн 30 жил зөндөө гарсан. Бүр 1991, 1992 оноос эхлээд л өмчийн маргаан одоо хүртэл явдаг.

Тэгээд үүний хамгийн сонгодог сүүлийн жишээ болов уу л гэж харж байгаа юм л даа.

Тэгэхээр ийм маргаан уг нь явмааргүй байгаа юм. Үүнийг нэгмөсөн яг төрийн өмч гэж юуг ойлгох юм. Тийм ээ. Буцаад яг Төрийн өмчийн хороо яг ямар эрх үүрэгтэй байх юм. Энэ хуулийн шинэчилсэн найруулга дээр Та бүхэн саналаа өгөх ёстой гэж бодож байна. Яг ийм тод жишээ гарч байгаа дээр Та бүхний асуудал яг одоо энэ Улсын Их Хурал дээр явж байгаа хууль дээр засагдаж орж байна уу, үгүй юу? Дахиж ийм маргаанаас бид сэргийлж чадах уу, үгүй юу гээд.

Тэгэхээр яг иймэрхүү дахин жишээ битгий гараасай. Энэ асуудлыг хуулиараа нэгмөсөн бид цогцоор нь шийдээсэй л гэж бодож байгаа юм л даа.

Тэгээд эндээс явж явж дахиад хохирогч нь дахиад л олон нийт, иргэд. Энэ дотор дандаа шинэ “старт ап” үүсгэх гээд л явж байгаа. Тийм ээ. Шинэ үнэ цэн үүсгэх гээд, дараагийн тэрбум долларын бизнес үүсгэх гээд явж байгаа залуучууд л хохирч үлдэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүний чинь алдагдсан боломж гэх юм бол дахиад л бид ийм олон “старт ап” гаргаад эко систем үүсгээд явах тэр боломжууд бүгдээрээ алдагдсан боломж л тооцогдоод л явна л даа.

Түүн дээр нэг ийм жижигхэн өмчийн маргаанаас болоод боломжоо алдмааргүй байна.

Асуулт гэхээсээ илүү санал. Та бүхэн тэр хуулийн төсөл О.Номинчимэг гишүүн дээр явж байгаа. П.Сайнзориг гишүүн дээр явж байгаа. Хоёр хууль зэрэг явж байгаа. Д.Үүрийнтуяа гишүүн дээр явж байгаа.

Тэгэхээр Та бүхэн бас тэр хуулийн төслийг авч нэгэнтээ яг ийм сүүлийн жишээ гарч байгаа бол яг энэ дээр Та бүхний асуудал шийдэгдсэн байна уу, шийдэгдэх нь үү гэж заавал хараасай гэж бодож байгаа юм.

Тэгээд энэ дээр зүгээр ганц асуулт байсан. Тэр нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар. Одоо Төрийн өмчийн хороо энэ дээр яг ямар байр суурьтай байгаа юм? Би түр хоцорсон. Энэ дээр яг албан ёсны байр суурь байгаа юм уу? Уг нь та нар биш Төрийн өмчийн хороо энэ дээр асуултад нь хариулаад явж байх ёстой юм биш үү гэсэн ийм л асуулт.

Ч.Анар: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Баяр-Эрдэнэ. Индрийн микрофон.

Ц.Баяр-Эрдэнэ: О.Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Түрүүн асуултауд нэлээн давхацсан.

Тэгэхдээ би ерөнхийдөө товчлоод хариулъя. Энэ түрээсийн асуудал 2010 онд анх бий болоод, тэгээд улмаар 2012 онд түрээсээ хөрөнгө оруулалт хэлбэр лүү шилжүүлэх асуудал яваад, 2015 онд тухайн үеийн Төрийн өмчийн хороо түрээсийг нь хөрөнгө оруулалт гэсэн байдлаар хүлээн зөвшөөрөөд, тухайн үеийн Төрийн өмчийн хороо 2015 онд татан буугдсан байдаг.

2016 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар байгуулагдаад энэ IT Park дээр бий болсон асуудлыг бас тухайн үед нэлээд олон талаас нь авч үзээд, энэ асуудал дээр ер нь эргэж харах ёстой юм байна гэдэг ийм шийдвэрийг тухайн үеийн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хурлаар гаргаад, ингээд шүүхийн процесс үндсэндээ эхэлсэн.

Яг энэ гэрээний хугацаа 2023 онд дуусах байсан учраас 2023 онд яг дуусах үед нийслэлийн прокурор ер нь төр хохирсон хэд хэдэн асуудлуудыг багцлаад энэ дотор төр төлөөлж нэхэмжлэл гаргасан байгаа юм.

Тэгээд энэ дотор IT Park-ийн асуудал байсан.

Ингээд нэхэмжлэгч байгууллагаар Нийслэлийн прокурор, IT Park, хоёрдогч этгээдээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хамтарч ажиллаад ингээд гурван шатны шүүхээр өнөөдөр үндсэндээ асуудал шийдэгдээд байж байгаа.

IT Park 790.0 сая төгрөг гаргаж өгөх ийм гурван шатны шүүхийн шийдвэр гарсан. Ийм байдалд байгаа.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 2016 оноос хойш энэ асуудлыг хууль хяналтын байгууллагад тавьж асуудлыг нь шийдэхийн төлөө хууль зүйн хүрээнд ажиллаж ирсэн гэдгийг хариуцлагатайгаар хэлье.

Ч.Анар: О.Батнайрамдал гишүүн тодруулъя.

О.Батнайрамдал: Сая Та түрээслээд хөрөнгө оруулах гэсэн үү? Тийм ээ.

Тэгэхээр ийм яг сайн жишиг байна уу? Өөр яг энэ ганцаархнаа биш байлгүй дээ. Иймэрхүү гэрээ яг ямар ямар компаниуд, эсвэл байгууллагууд дээр хийгдсэн. Тэр бүхнээс сайн жишиг болоод явсан юм. Хэд нь өнөөдөр жишээлбэл бас ийм шүүхийн асуудалтай явдаг юм? Эсвэл ганцхан энэ IT Park дээр л хийгдсэн цор ганц жишиг юм уу?

Ч.Анар: Индрийн микрофон.

Ц.Баяр-Эрдэнэ: Төрийн болон орон нутгийн өмчийн хуулиар төрийн өмчийн түрээслэх асуудлыг Засгийн газрын тогтоолоор батлаад журамлаад шийдвэрийг нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хэрэгжүүлээд явдаг.

Түрээсийн гэрээний хувилбар их олон янз. Сургуулийн цайны газрыг, эмнэлэгийн аптекийн зориулалттай байрыг түрээслэхээс өгсүүлээд энэ Ай Тигийн чиглэлийн антенуудыг өндөр байшин дээр төрийн өмчийн байшин дээр байвал түрээслэхээс эхлээд маш олон янз.

Энэ түрээсийн хэлбэр маань өөрөө хөрөнгө оруулалтаас маш ялгаатай.

Тэгэхээр энэ асуудлыг эхлээд нэг хуулийн этгээд түрээсийн гэрээ байгуулж явж байгаад тэр түрээсийн эрхээ натурт шилжүүлээд, тэгээд тэр компани нь хөрөнгө оруулалт хийсэн гэдэг ийм асуудал гаргаж тавиад. Тэгээд тухайн үед зохицуулагч байгууллага болох Төрийн өмчийн хороогоор хөрөнгө оруулалтаа баталгаажуулсан ийм л зүйл байгаа.

Тухайн үеийн Төрийн өмчийн хороог баталгаажуулахдаа хүлээн зөвшөөрөөд, тэрийг нь мэргэжлийн хөрөнгийн үнэлгээний байгууллагаар баталгаажуулахдаа бас нэг байгууллага тэрийг нь гаргаж өгөөд ингээд баталгаажуулсан.

Гэхдээ үүнийг бол төрийн өмчит бүртгэсэн юм уу, төрийн өмчит авсан тухай тийм шийдвэр байхгүй.

Ингээд шүүхийн маргаан үүсгэх гол үндэслэл үүссэн ийм л зүйл байгаа.

Адилхан жишээ. Би яг одоо нарийн юм хэлж мэдэхгүй байна. Адилхан жишээ байхгүй байх аа. Энэ чинь түрээсийн гэрээ хөрөнгө оруулалтын гэрээ болж хувирсан л... /минут дуусав/

Ч.Анар: Нэмэлтийн дараа О.Батнайрамдал гишүүн дахин тодруулъя.

Д.Дэлгэрмаа: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа.

Яг сайн жишиг гэдгийг ерөөсөө санаанд байхгүй байна. Яах вэ, энэ хөрөнгө оруулалт биш уг нь засан сайжруулалт гэж явдаг. Иргэний хуулиараа.

Тэгээд өмчлөгчийн зөвшөөрлийг авсны үндсэн дээр тэр хөрөнгө оруулалт буюу засан сайжруулалтыг хийх ёстой. Өөрөөр хэлэх юм бол тэр хөрөнгө оруулалт гээд байгаа тэр засан сайжруулалтаа хийхээсээ өмнө зөвшөөрлөө авна гээд манай энэ гэрээний журам, гэрээн дээр ч угаасаа байж байгаа.

Хийхээсээ өмнө зөвшөөрлөө авч байж зураг төсөв, ийм хэмжээний төсөв орох гэж байна шүү, төсөвтэй зардал орох гэж байна шүү. Энэ гарсан зардлаа дараа нь түрээсийнхээ орлогоосоо яаж суутган тооцох юм гээд ийм процессууд уг нь хийгдэх ёстой юм. Тэгж байж маргаан үүсэхээс сэргийлэх ёстой. Иргэний хууль дээр ч угаасаа тийм юутай байж байгаа.

Гэтэл 2010 онд хийсэн түрээсийн гэрээг маань 2015 онд хөрөнгө оруулалтыг нь шууд... /минут дуусав/

Ч.Анар: 1 минут.

Д.Дэлгэрмаа: Зөвшөөрөлгүй хийсэн тэр хөрөнгө оруулалтаа хожим нь баталгаажуулснаараа энэ маргааны үндэс нь бий болсон юм. Анхнаасаа уг нь зөвшөөрлөө аваад хийх байсан.

Ч.Анар: О.Батнайрамдал гишүүн дахин тодруулъя.

О.Батнайрамдал: Хуулийн газрын даргаас бас дахин нэмэлт тодруулъя.

Энэ кэйс бараг ганцаараа шахуу л юм байна л даа. Та микрофон дээр оч.

Тэгэхээр одоо ер нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар түрээсийн хэдэн гэрээ байдаг юм? Ер нь үүнийг бүгдийг нь анализ хийгээд, дүгнэлт хийгээд гаргасан тийм тайлан байгаа юу? Хэдэн маргаан явдаг юм? Тийм ээ. Тэгээд маргаан нь шийдэгдсэн үү? Хэд нь шийдэгдээд, хэд нь одоо хүртэл шүүх дээр маргаантай яваа юм? Тийм ээ.

Тэгэхээр нэг ёсондоо төр өөрөө баахан өмчтэй бол түүний захиран зарцуулалт хэрхэн хийгдсэн талаар уг нь бид хамгийн сайн мэдэх л ёстой л доо.

Тэгэхээр энд энэ дээр ямар тийм тайлан дүгнэлт байдаг юм бол оо? Тэгээд үүн шиг бас өөр төрийн өмчийн том маргаантай кэйс байна уу?

Ч.Анар: Индрийн микрофон 3 минут.

Д.Дэлгэрмаа: Яг тодорхой тоог мэдэхгүй байна. Жилд 2 мянга гаруй түрээсийн гэрээг баталгаажуулж явж байгаа.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар гуравласан гэрээ түрээс дээр байгуулдаг. Түрээслэгч, түрээслүүлэгч, тэгээд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар гээд гуравласан гэрээ байгуулаад явж байгаа.

Миний санаж байгаагаар сүүлийн 5 жил түрээсийн маргаан үүнээс өөр байхгүй. Одоо үүсэж байгаа маргаан нь түрээсийн сонгон шалгаруулалттай холбоотой 4, 5 маргаан шүүх дээр явж байгаа. Сонгон шалгаруулалтын.

Түрээсийн хөрөнгө оруулалтыг баталгаажуулсантай холбоотой хохирол гэсэн ийм маргаан бол байхгүй явж байгаа.

Ч.Анар: Гишүүд үг хэлж болно. Асуулт асууж, санал сонссоны дараагаар.

Би тодруулгаа авъя. Түрүүн Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа болон Ц.Баяр-Эрдэнэ тайлбарлаж байна.

Эзэмшигч буюу IT Park өөрөө хариуцна гээд байх юм. Төрийн өмчийн хороо өөрөө хяналт тавих чиг үүрэг нь байгаа шүү дээ. Одоо энэ хууль дээрээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараах бүрэн эрхтэй.

Нэг.Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хянах.

Тэгэхээр өртгөөс нь доогуур, шударга бус, илт ашиг сонирхлын зөрчилтэй хэлэлцээр явж байхад Та бүхэн 14 жил бид нарын мэдэхгүй асуудлаа гээд бүх төрийн өмчид ингэж ханддаг юм уу?

Тэгэхээр энэ чинь хуулийн заалттай байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр яагаад арга хэмжээ аваагүй юм. Одоо ч гэсэн арга хэмжээ авахгүй яваад байгаа юм бэ? Үүнийг дахин дахин тодруулъя.

Хоёрдугаарт, энд шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрынхан ирсэн байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хоёр тал харилцан зөвшилцөлд ороод IT Park бол түрүүн танилцуулга дээрээ дурдсан. Төлбөрийг хувааж төлөх бололцоотой. Тэр хувааж төлөх график тохирье гэхэд тэр саналыг хүлээж авалгүйгээр шууд арга хэмжээг гүйцэтгэсэн байна.

Энэ тал дээрээ ер нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийнхээ талаар болон саяын асуултад хариулж өгөхийг хүсье.

Ц.Баяр-Эрдэнэ дарга.

Ц.Баяр-Эрдэнэ: Ч.Анар гишүүний асуултад хариулъя.

Хуулиар ер нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн эзэмшилт, ашиглалтыг маш тодорхой хэн хариуцахыг нь заагаад өгсөн байгаа.

Тэгээд эзэмшигч байгууллага ер нь хөрөнгийн эзэн нь байдаг.

Өнөөдөр Монгол Улсад 6 мянга гаруй төрийн өмч дээр суурилсан үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрлийн байгууллагууд хөрөнгийнхөө эзэмшилтийг өөрсдөө хариуцаад явдаг.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар бүртгэлээр, хяналт шалгалтаар холбогдох зохицуулалт буюу зөвшөөрлөөр хяналт тавьж ажилладаг. Энэ хүрээндээ энэ хуулийн 11-ийн хэрэгжилтийг хангаад явдаг ийм л зохицуулалт байгаа.

2010 онд IT Park дээр үүссэн гэрээний асуудал яваандаа хөрөнгө оруулалтын шинжтэй асуудал болоод, 2015 онд хөрөнгө оруулалтыг нь баталгаажуулсан шийдвэр нь тухайн үед энэ ажил, алба албан тушаал хашиж байсан хүмүүсийн хариуцлагагүй үйлдэл гэдгийг би түрүүн хэлсэн.

Нийслэлийн прокурорын газар төрд нэхэмжлэл гаргах эрхийнхээ дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтраад нэлээд олон хэрэг дээр. Та бүхэн энэ IT Park, Хөтөл цемент, төмөрлөг гээд энэ олон асуудлуудын хүрээнд энэ асуудлыг гаргаж тавьсан юм. 2017 оноос хойш энэ асуудал нэлээд түлхүү хөөцөлдөж явсан.

Би ажил хариуцаж байгаа хүний хувьд энэ асуудлыг бас чиг үүргийнхээ хүрээнд нэлээдгүй оролцоод явж байгаа.

Тийм учраас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар засаж залруулах ажлыг хууль, журмын хүрээнд хийгээд явж байгаа.

Тухайн үед тэр асуудал гаргасан албан тушаалтанд тавих асуудлыг бид хариуцагч байгууллага буюу манай IT Park-ийн төр төлөөлж хариуцаж байгаа манай Ж.Золзаяа бид ярьж байгаад гаргаад Нийслэлийн прокуророос... /минут дуусав/

Ч.Анар: Нэмэлт авах уу?

Ц.Баяр-Эрдэнэ: Нийслэлийн прокуророос Авлигатай тэмцэх газарт хандсан. Харамсалтай нь бид хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэдэг үндэслэлээр хэрэг хаагдсан юм байна гэж ойлгож байгаа.

Зүгээр цаашид хууль тогтоомжийг, дүрэм журмыг боловсронгуй болгох ёстой л гэсэн ийм л бодолтой байна.

Ч.Анар: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар.

Б.Даваадорж: Та бүгдийн амрыг эрье.

Би Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албаны дотоод хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Б.Даваадорж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд төлбөр төлөгч, төлбөр авагч талууд харилцан тохиролцох бүрэн боломжтой байгаа. Ингэхийн тулд төлбөр төлөгч, төлбөр авагч нар харилцан тохиролцсон албан бичиг байдаг юм уу. Тийм ээ. Хоёр талаасаа шийдвэр гүйцэтгэгчдээ баримтаа гаргаж өгөх ёстой юм.

Шийдвэр гүйцэтгэгч нь тухайн тэр баримтыг үндэслээд шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаа баталгаажуулаад тэмдэглэл хөтлөх юм.

Ингэж харилцан тохиролцсоны дараа төлбөрийг хэсэгчлэн болон эсвэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1.4-д заасны дагуу дуусгавар ч болгох бүрэн боломж нээлттэй байдаг.

Энэ “Нью Тур Сафарис” болон Мэдээлэл технологийн үндэсний парк төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай холбоотой гүйцэтгэх баримт бичиг Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр ирсэн байдаг. 232 дугаар тойргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан.

Ингээд 2626 метр квадрат талбайтай объектыг 12 сарын 15-ны өдөр Мэдээлэл технологийн үндэсний паркт хүлээлгэж өгсөн байдаг. Зөрүүлээд 791.0 сая төгрөг, дээрээс нь мөн тэмдэгтийн хураамжийн 42 сая төгрөгийг гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг одоо яг явуулж байгаа.

Ч.Анар: Гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Тэгэхээр одоо салбарын төлөөлөл болсон төрийн бус байгууллагаас хоёр санал, Б.Жаргалан болон Р.Батболд гишүүний хүсэлтийн дагуу хувийн хэвшлээс санал хэлэх хүмүүс байна уу?

Нэрсээ өгөөд 4 саналыг авъя. Дэгийн тухай хуулийг зөрчиж байгаа шүү.

Тэгэхээр Та бүхэн яг 4 хүн 3, 3 минутад багтааж саналаа хэлье. Түүний дараагаар Их Хурлын гишүүд үг хэлж болно.

Индрийн микрофон дээр 4 хүн очоод 3, 3 минутад багтаагаад саналаа хэлэх шаардлагатай байна. Нэр, албан тушаалаа танилцуулаарай Та бүхэн.

Л.Хулан: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Мэдээллийн технологийн нэгдсэн холбоо “МИТА” төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал Л.Хулан байна.

Өнөөдрийн IT Park-тай холбоотой зүйлсийг бид урьд нь нэлээн дэмжиж ажилласан байгаа. Тэгээд энэ удаа бас дахиад дэмжиж ирж байна.

Тэгээд өнөөдөр мэдээллийн технологийн асуудлыг digital-first буюу “цахимаар нэн тэргүүн” гэсэн энэ салбарын асуудлыг Ерөнхий сайд Г.Занданшатар урьд нь байхдаа гаргаж тавьж байсан.

Тэгээд Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг түүчээлж явах мэдээллийн технологи маань хамгийн нэн тэргүүнд гэсэн энэ салбарыг түүчээлээд явах ийм боломжийг олгож байгаа.

Тэгээд яг энэ салбар дээр тулгараад байгаа асуудлуудыг бид өнөөдөр нэлээн буруушааж, яагаад яг ийм асуудал үүсээд байгаа юм. Цаашид Монгол Улсыг технологийн хувьд, инновацын хувьд авч явах хамгийн гол салбар маань энэ байхад ийм харамсалтай зүйлүүд тохиолдоод байна.

Тэгээд Ж.Золзаяа захирал маань болохоор өөрийнхөө үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж чадахгүй гэдгийг Их Хурлын гишүүд Та бүхэн бүгдээрээ түрүүн хэлж байна.

Тэгээд энэ хүн чинь энэ улсын тэргүүлж явж байгаа салбарыг түүчээлээд явж байгаа олон эмэгтэйчүүдийн нэг нь гэж бид харж байгаа.

Тэгээд энэ эмэгтэй хүнийгээ бид дэмжээд ажиллах гээд, тэгээд Их Хурлын гишүүд маань цуглаад Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хороогоороо дэмжээд ажиллаж байгаад нь бид баяртай байна.

Тэгээд Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль маань батлагдаад явж байгаа ч гэсэн бас бид санал санаачилгаа оруулаад явж байгаа.

Та бүхэнд удахгүй нэлээн цар хүрээтэйгээр шинэ томилогдсон сайд Ч.Номин болон Их Хурлын гишүүд, тэгээд улмаар Ерөнхий сайд Н.Учралтай уулзаад, энэ 4 сардаа багтаагаад энэ хуулийн санал, санаачилга дээр оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийг бид танилцуулна гэж байгаа.

Тэгээд манай мэдээллийн технологийн холбоодууд саналуудыг боловсруулсан.

Тэгээд ийм сайхан боломж олдож байхад IT Park дээр үүсээд байгаа, ганцхан нэг хувийн хэвшил энэ дээр давамгайлаад түрэмгийлсэн бодлого баримтлаад, өнөөдөр хүртэл ямар ч хүндэтгэл байхгүй. Хүрч ирээгүй. Тийм ээ. Түүнд харамсаж байна. Тийм болохоор бид хамтдаа цаашаа тууштай энэ асуудлын талаар явна гээд холбоод маань ирсэн байна.

Тэгээд манай гишүүн байгууллагууд ч гэсэн бас үүнийг дэмжсэн учраас манай Удирдах Зөвлөлийн гишүүд ч гэсэн ирсэн байгаа.

Тэгээд Их Хурлын гишүүд Та бүхнийг дэмжиж ажиллаарай гэж хүсмээр байна.

Тэгээд холбоод хувийн хэвшлээ дэмжиж ажилласнаар Монгол Улсын эдийн засаг маань улам цаашаага эрч хүчтэй явж, татвар төлөгчид маань ч гэсэн өөрсдөө татвараа төлж... /минут дуусав/

Ч.Анар: 3 минут.

Б.Адилбиш: Юуны түрүүнд энэ сонсголыг зохион байгуулж байгаа дэд хорооныхондоо баярлалаа. Маш их мэдээллийг авлаа.

Тэгээд энэ асуудлыг ил гаргасан Мэдээлэл технологийн Үндэсний парктаа баярлалаа.

Тэгээд эндээс ийм зүйлүүд харагдаж байна л даа. Одоо бид ингээд арван хэдэн жилийн өмнөх үйл явдлыг, бүр шүүхээр тогтоогдсон үйл явдлыг яриад сууж байна л даа. Уг нь бид инновацаа ярьж байх ёстой, өрсөлдөөнээ ярьж байх ёстой, асуудлаа ярьж байх ёстой байтал төрийн байгууллагуудын хоорондын харилцааг яриад сууж байгаадаа нэгдүгээрт харамсаж байна.

Тэгээд нэгдүгээрт хөрөнгө оруулалтын шийдвэр гарсан оныг Мэдээлэл технологийн үндэсний парк болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хоёр өөрөөр яриад байна. 2012 он гэж яриад байна. 2015 он гэж яриад байна.

Тэгээд гэрээний тэр түрээсийн үнийг доод үнийг Сангийн яамнаас баталж өгдөг гэсэн. Тэгээд гуравласан гэрээ байгуулсан гэсэн. Нөгөө аудитын байгууллага хаана юу хийж байсан бол. Гэрээ байгуулсан байхад тухайн үед аудитын байгууллага энэ доод үнээсээ доор байна шүү дээ гэдэг шийдвэрийг аль хэдийн тухайн цаг мөчдөө гаргах боломж байсан.

Дараа нь хөрөнгө оруулалтын шийдвэр гарсан байна. Төрийн өмийн газраас. Тийм ээ. Гэтэл IT Park 5.2-оор шийдвэр гарсан байхад 3-аар бүртгэлийг хийсэн байна. Тийм ээ. Энд бас аудитын байгууллага хаана байна. Энэ чинь аягүй ойлгомжтой зүйлс. Тийм ээ. Аудитын байгууллага төрийг эрсдэлээс хамгаалах ёстой. Өнөөдөр бид нарыг ийм байдалд оруулахгүйн тулд аудитын байгууллага ажиллаж байгаа.

Одоо тэгэхээр бид үүнээс цааш дахиж ийм байдалд орохгүйн тулд яг энэ виртуал бүсийн үйл ажиллагаа, энэ үйл ажиллагаанууд дээрээ аудитын байгууллагатайгаа хамтарч ажиллая. Энэ чиглэлээ таниулъя, мэдрүүлье. Доор бүр нь аудит үүнийг илрүүлж байх ёстой болохоос биш бид нэгдэж суугаад ч юм уу, шүүх байгууллагын шүүх нь өөрөө аягүй сонин зүйл надад санагдаж байна.

Би Монголын программ хангамжийн нэгдсэн холбооны Гүйцэтгэх захирал Б.Адилбиш. Баярлалаа.

Тэгэхээр миний санал бол Виртуал бүсийн үйл ажиллагаан дээрээ аудитын байгууллагыг бас оролцогчоор татаж оруулъя. Үнэхээр хүрэх Ёстой сегментдээ хүрч байна уу гэдгээ аудитын байгууллага доор доор нь шалгадаг байгаасай гэж хүсэж байна.

Ч.Анар: Баярлалаа. 3 минут. Та нэр, албан тушаал.

Б.Тамир: Дижитал Нексус компанийн үүсгэн байгуулагч Баярсайханы Тамир.

Мэдээллийн технологийн салбарынхны түүдэг галыг IT Park гэж хардаг.

Тэгээд энд илүү ойрхон байж, эндээс олон олон гарааны бизнесүүд хурдтай өсөлт, тэлэлтийг хийж явж чаддаг гэж хардаг. Энэ байгууламжийн өмчийн маргааны асуудал шийдэгдвэл бид нарт цаашид маш олон боломж байгаа гэж харж байгаа.

Зүгээр надад сонин санагдаж байгаа нь энэ “Нью Тур Сафарис” гэж нэхэмжлэгч компани, мөнгө авах гэж байгаа компани хаана байгаа юм бэ. Энэ төрийг хүндлэхгүй байгаа юм уу гэдэг нь аягүй сонирхолтой санагдаж байна.

Цаашид бид яг юу хийж болох вэ гэхээр энэ тэлээ хурга шиг явдаг IT Park-ийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамных нь харьяанд өгөх нь зүйтэй гэдгийг мэргэжлийн төлөөлөгч байгууллагуудын зүгээс хэлмээр байна.

Хоёрдугаарт, сая нөгөө зураг төслийн уралдаан болсон. Тийм ээ. Залуучуудаас маш олон саналууд гарч байсан. Энэ IT Park-ийг цаашид дэд бүтцийн код хөгжүүлэх гэж байгаануудад нь, Эй Ай хөгжүүлэх гэж байгаануудад нь маш том дэд бүтцийн төв болоосой, лабораториуд бий болоосой гэж харж байгаа.

Тэгэхээр бид нарт олон улсын хамтын ажиллагаа Ж.Золзаяа захирлын үед маш сайжирсантай холбоотойгоор сайн жишгүүдийг аваад нэвтрүүлээд шууд ажил хэрэг болгох боломж байгаа гэж харж байна.

Дараагийнх нь асуудал одоо энэ өмчийн маргааны асуудал дээр анхаарал хандуулаад яваад байгаа.

Уг нь Виртуал бүсийнхээ тухай хуулийн хэрэгжилт дээр анхаараад эрх, үүргээ эдлээд хэрэгжүүлээд явах нь гол ажлуудын нэг. Хүлээгдэж байгаа. Виртуал бүс дээр компаниуд бүртгүүлээд байдаг, бүртгүүлээд байдаг. Хэзээнээс нөгөө хөнгөлөлт урамшуулал, илүү боломжуудаа эдэлж эхлэх юм. Хэнд ч тодорхой биш.

Оролцогч талуудын хамтын ажиллагааг Цахим хөгжил, харилцаат харилцаа холбоо, инновацын яам хариуцаж ажиллах ёстой. Юу хийж байгаа вэ гэдэг ийм асуулт эргэлзээ байна. Хэзээнээс юм бол гэдэг тодорхойгүй байдал байна. Тэгээд баярлалаа.

Ч.Анар: 3 минут. 4 хүнээр тасалсан байгаа. Сүүлийн хүн.

Д.Санжсүрэн: Эрхэм улс Улсын Их Хурлын гишүүд Та бүхэндээ бид нарыг хүлээж авч байгаад маш их баярлалаа.

Би “Artum” компанийн үүсгэн байгуулагч гарааны компани. Д.Санжсүрэн гэдэг хүн байгаа.

IT Park нуур юм. Бид нуурт байдаг загас юм. Тэгэнгүүт нуур өөрөө бүр замаг сайтай байж загас сайхан үржинэ. Тэгэнгүүт л нуурыг бохирдуулж байгаа ч гэх юм уу, бид нуураа гялс цэвэрлэж аваад хүрээлэн буй орчинд ээлтэй болгохгүй бол нэг тогтоол болох тал руугаа явж байна гэж харж байгаа.

Тэгээд загас энэ дотор бид амьдрахад улам л хүнд болж байна.

Тэгэхээр сая мэдээллүүдийг авч байхад IT Park маань өөрөө аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар. Тэгээд өөрөө өөрийгөө санхүүжүүлэх ёстой, ашиг олох ёстой гэж бараг тал талаас нь шахдаг бололтой гэж би ойлгогдож байна. Тэгэнгүүт нөгөө ашгийг нь “старт ап” компаниуд нь өөрөө түрээсээр тэрийг бүрдүүлдэг, цалинг нь өгдөг.

Тэгэхээр бүх юмны үнэ орж байгаа. Тийм ээ.

Тэгэхээр энэ талаасаа гэх юм технологийн компаниуд л өөрөө бас тэрийг төлдөг болчхож байгаа. Нөгөө талаас технологийн компаниудыг дэмжиж байгаа дэмжлэгүүд өөрөө юу байгаа билээ. Тийм ээ. Бид Засгийн газрын 39 дүгээр тогтоол гарсан журамтай л бол гоё болох гэж байна гэсэн. Нэг ч хэрэгжээгүй. Бид нэг ч хөнгөлөлтүүд авч чадаагүй.

Хоёрдугаарт, бид хуультай болчихвол гоё боллоо гэсэн хүлээгдэж байна. Виртуал бүсийн журамтай болчихвол гээд тодорхойгүй юмнууд хүлээгдэж байна. Тэгэнгүүт л бид энэ загаснууд нь яг яах вэ.

Тэгэнгүүт гадуур юу гэж ярьж байгаа вэ гэхээр танай салбар алж байна уу. Хиймэл оюун ухаан дээр, их өгөгдөл дээр юм гаргаад л, та хэд алаад л та хэдийг дэмжээд л, пүүх та хэд л мөнгө олоод байх шиг байна аа.

Тэгэхээр бид нэг их алаад байсан юм байхгүй. Харин ч эсрэгээрээ бид хүн амын орлогын албан татвараа яах вэ, НӨАТ яах вэ, түрээсээ яах вэ, цалингаа

ях вэ. Одоо сүүлдээ бид томоохон компаниудын хүний нөөцийг бэлдэж өгдөг дамжаа болсон.

Танай компани ийм бүтээгдэхүүн хийсэн гэж байна. Танай хэн хийсэн юм. Окэй. Тэр залуу руу чинь яриад, тэр нөгөө залуучууд руу энэ шийдлийг хийгээд өгчих. Мөнгө амладаг болсон гэдэг ч юм уу. Тийм ээ.

Тэгэхээр бид нарт ярих юм олон байна. Түрүүн Б.Жаргалмаа гишүүний асуултад буцаагаад базаад хариулахад ямархуу бүтэцтэй байх юм бэ гэдэг шиг ямар ч байсан нэг түрээсийн араас хөөцөлддөггүй, үндсэн үйл ажиллагааныхаа араас чиглүүлдэг, тэгээд төрөөс санхүүжилтээ авдаг, үндсэн санхүүжилтдээ санаа зовдоггүй хамтдаа хөтлөлцөөд урагшаа хардаг... /минут дуусав/

Ч.Анар: Баярлалаа. Салбарын төлөөлөл үг хэлж дууслаа. Тэгвэл сүүлийн хоёр хүнээр нэр тасалъя. Сонсчихъё. 3 минут.

Дэгийн тухай хуулийг зөрчиж бас Та бүхэнд боломж олгогдож байгааг бас ойлгоорой.

Б.Хүрэлбаатар: Ойлголоо. Баярлалаа. “OnePlaceHR Technologies” компанийн гүйцэтгэх захирал Б.Хүрэлбаатар байна.

Манайх яг Монгол болон Узбекистаны IT Park-ийн резидент компани юм.

Тэгээд би нэг жижигхэн харьцуулалт хэлээд араас нь нэг санал хэлэх гэсэн юм.

Узбекистаны IT Park-т үйл ажиллагаа явуулж байгаа компани маань тэг татвар төлдөг. Тэгээд дээрээс нь IT Park нь өөрөө хөрөнгө оруулалтынтын сантай. Бид манай Узбекистаны компани тэндээс хөрөнгө оруулалт аваад Узбекистанд үйл ажиллагаагаа явуулж байгаа.

Монголд бид хэд нэг тооцоо хийгээд үзсэн. Манай компанийн дансанд орж ирж байгаа мөнгийн бараг 50 хувь нь татвар болоод гардаг.

Тэгээд дээрээс нь манай IT Park-ийн буруу биш л дээ.

Тэгэхдээ байгаа байдал нь. Тийм ээ. Бид яаж үйл ажиллагааг нь зогсоохгүй байлгах вэ гээд бараг кэйшаар төлбөрөө төлөх үү, үгүй юу гээд тийм юм ярьж байгаа. Ийм өрөвдөлтэй байдалд байгаа юм.

Тэгэнгүүт бид сая хөрөнгө оруулалт аваад тэрийг буцаагаад Монгол руу яаж доллар оруулж ирэх вэ гэнгүүт нөгөө манай хөрөнгө оруулагч маань та нар заавал ийм 50 хувийн татвар төлдөг энэ газар луу мөнгө оруулж ирэх хэрэг байгаа юм уу гэхээр манай инженерүүд ипотекийн зээл авах гээд байгаа учраас л бид

Монголд ингээд энэ компаниа байлгаад байгаа гэсэн үг. Түүнээс бид Монголд ер нь үйл ажиллагаа хиймээргүй байгаа.

Би энэ дээр ганцхан л санал хэлэх гэсэн юм. Цахим яаманд хамаарах байх гэж бодож байна. Бид өөрсдийн гэсэн хуультай. Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуультай. Тэндээс ганцхан заалтыг энэ жилдээ хэрэгжүүлээд өгөөч ээ. Тэр нь нийгмийн даатгалын шимтгэл. Үүний буцаан олголт. Тэгэхгүй бол бид орлого олж байгаа бол бид орлогын албан татвар төлөхөд асуудалгүй ээ. Борлуулалт хийж байгаа бол бид НӨАТ-аа төлөхөд асуудалгүй. Яагаад хүн ажиллуулаад байгаа юм бэ гэдэг ийм татвар шиг юм байгаа байхгүй юу. 22.5 хувь.

Тэгэхээр нийгмийн даатгалын шимтгэл гэдэг. Энэ буцаан олголтыг шийдээд өгчихвөл дөнгөж төрж байгаа старт апуудад аягүй их дэмжлэг болно. Яагаад гэвэл Ай Ти-гийн компаниуд эхнээсээ борлуулалт хийж чаддаггүй. Маш их хугацаагаар хэдэн сараар юм хөгжүүлдэг. Тэр хугацаанд байнгын өрөнд орсоор байгаад дансаа хаалгаад. Одоо энд дансаа хаалгаж үзээгүй компани бараг байхгүй байх гэж бодож байна. Дансаа хаалгаад тэгээд цалингаа тавьж чадахгүй том компаниудтай банкуудтай хөгжүүлэгчийн цалингаар өрсөлдөж чадахгүй байж байж нураад уначихдаг.

Тэгэхээр IT Park-т дэмжлэг үзүүлээд цахим яам энэ жилдээ ганцхан ажил хийгээд өгөөч ээ. **Нийгмийн даатгалын шимтгэлийн асуудлыг л шийдээд өгөөч** гэж санал тавих гэсэн юм.

Ч.Анар: 3 минут.

Т.Адъяатөмөр: Сайн байцгаана уу? “CarePay” төслийн үүсгэн байгуулагч Т.Адъяатөмөр.

Манай компанийн хувьд мөн адилхан сүүлийн 2 жилийн хугацаанд олон улсын 3 чанартай **accelerator** хөтөлбөрт яваад ирсэн ийм компани.

Тэгээд энэ өмчийн маргааны хувьд угаасаа ойлгомжтой. Энэ бол зүгээр л боловсон хулгай. Энэ дээр ахиад нэмэлт коммент алга байна.

Саяын Б.Хүрэлбаатарын хэлсэн зүйл яг адилхан давтаад хэлж байгаа. Нэмэх нь ямар санал байж болох вэ гэхээр сая Киргиз би бас яваад ирсэн. Киргизид олон улсын Агаханы (Aga Khan Development Network) ийм олон улсын network-оос авсан бас ийм accelerator хөтөлбөр, fund нээгдсэн байна лээ.

Тэгээд тэр бол ингээд тухайн улсынхаа хамгийн sustainable-тэй уялдаатай төслүүд рүү хийдэг ашгийн бус ийм сан, байгууллага байдаг.

Тэгэхээр бид зөвхөн төрийг харахаас гадна олон улсын боломж бололцоонуудыг хувийн ашиг сонирхлоос гадна олон улсын нийгмийн сайн сайхны төлөө хийдэг сангуудыг татах ажлуудыг хийх юм бол нэлээн чухал. Нэг.

Хоёрт, статусын хувьд IT Park мэдээж улсын өмчит болох нэг хувилбар. Өөр нэг хувилбар бол төрийн бус болох бас нэг хувилбар байж болно. Жишээ нь, Astana Hub бол төрийн бус статустай хэрнээ компанийн засаглал маягтайгаар явагддаг. Төрийн өмчит төрийн нөгөө support-оор байгуулагдсан хэрнээ Узбекистан style улсын өмчит хэлбэртэйгээр явагдаж байгаа.

Тэгэхээр зорилгоосоо хамаараад аль статус нь зөв бэ гэдгийг сонгох дээр бас нэг ярилцах нь зүйтэй байх.

Зүгээр миний хувийн бодол бол төрийн өмчит статустай хэвээрээ байгаа нөхцөлд ямарваа нэгэн төрийн ашиг сонирхол ямарваа нэгэн зүйл байсаар л байх болов уу. Ялангуяа Монгол шиг улс оронд бол энэ бас нэг бодох ёстой асуудал юм болов уу гэж бодож байна.

Нөгөөтээгүүр өнөөдөр IT Park-ийн тухай ярьж байгаа хэрнээ энэ бол салбарын ирээдүйн тухай ярьж байгаа асуудал. Тийм ээ. IT Park бол энэ салбарын эко системийг зангидах ёстой зангилаа.

Тэгэхээр үүн дээр онцгой ач холбогдол өгөх нь зүйтэй гэж бодож байгаа.

Би шулуухан нэг шүүмж хэлье гэж бодож байна. Өнөөдөр мэдээж дэд хорооны ажлын хэсгийнхэн байх. Цахим салбарт санаа зовнидог Их Хурлын гишүүд хүрэлцэн ирсэн явдалд зохион байгуулж байгаа явдалд туйлын талархуштай.

Тэгэхдээ бараг Их Хурлын гишүүн болгоны ардаас амнаас нь IT, AI, Startup хөгжинө, дэмжинэ гэж ярьдаг үгүүдийн яг та нар дэмжээд байгаа юм байгаа юм уу гэж асуумаар байгаа юм.

Тэгэхээр үнэхээрийн Та нөхдийн хувьд бол дэмжээд байгаа хүмүүс байх гэж бодож байна. Чин зүрхнээсээ санаа зовниод хийгээд байгаа. Хэрвээ тийм бол та нар нэгдэн нийлж ямар лобби хийж байна. Нөгөө 126 болоод бусад харьяаны ойлгохгүйхгүй байгаа нөхдүүдийг ойлгуулахуулах ажил хийж байгаа юм уу. Тэрийг ойлгуулах нэн чухал байна.

Хоёрт нь, ам ажил хоёрыг нь зөрүүлдэг үгүй байлгамаар байна.

Аман дээрээ ёстой дэмжинэ, ална тална, IT бол нэг номер гэж байнга ярьдаг. Хаана байна IT нэг номер гээд дэмжээд яг хийгээд байгаа. Энэ бол нэг талаасаа эс үйлдэхүй. Тийм ээ. Нөгөө бол эсрэг үйлдэхүүний ажил хийгдэж байгаа.

Тэгэхээр үүнийг нэг талаасаа шүүмжлэлтэй юм шиг хэрнээ нөгөө талдаа бодох ёстой асуудал юм болов уу гэж бодож байна.

Ингээд өнөөдрийн арга хэмжээн дээр эхэлсэн хүмүүс одоогоор байхгүй л байна л даа. Бас байж байх ёстой л байх. Үнэхээрийн энэ асуудал чухал гэж бодож байсан бол ямар ч ажил байсан гэсэн байж байх ёстой юм болов уу гэж ингэж бас бодож байна.

Өөр нэг юм бол түрүүний хэлсэн олон улсын хөгжлүүдийг харьцуулсан маягтайгаар Б.Хүрэлбаатар мань мэтийн энд тэнд явж байсан худлаа үнэн бадарчин хийсэн залуучуудаас санаа оноо сонсвол бид чинь бас нэг яалт ч үгүй алдаж оносон хүмүүс. Арай өөр зүйлсүүд хэлээд байж чадах байх гэж найдаж байна. Баярлалаа.

Ч.Анар: 3 минут.

Г.Дашжид: Бүгдэд мэнд хүргэе. Би Монголын программ хангамжийн нэгдсэн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, мөн “Интерактив” гээд энэ салбарт 30 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа IT-гийн компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Мэдээлэл технологийн нэгдсэн холбооны удирдах зөвлөлийн гишүүнээр мөн ажилладаг.

Тэгээд энэ хугацаанд бид салбарт 30 жил тогтвор суурьшилтай ажиллахын тулд маш их зүйлийг туулж байна.

Тэгэхээр мэдээлэл технологийн парк өндөр технологийн парк болж ирээдүйд хөгжөөд бид нарын энэ төвөгтэй 30 жил ингэж туучиж явсан замаар дараа дараагийн старт апууд маань битгий яваасай гэдэг нэг ийм үзэл бодлоор санал бодлоо илэрхийлэх гэж ирсэн. Нэгдүгээрт.

Хоёрт, товчхондоо нэг тов тодорхой жишээ авъя.

Мэдээлэл технологийн өндөр паркт төр бодлогоор өөрийн өмч болгож аваад энэ паркийг ер нь 22 сая долларын хөрөнгө оруулалт хийгээд 3 жилийн хугацаанд 15 сая долларыг буцаагаад олсон Киргизийн өндөр технологийн парк буюу хөгжлөөрөө яг манай улстай ижилхэн ийм улсын том жишиг байна.

Тэгэхээр энд ерөөсөө манай IT Park 1-ээс 3 га талбай дээр үйл ажиллагаа явуулж байгаа компани ийм аягүй жижигхэн асуудлыг яриад байгаа байхгүй юу бид нар. Гэтэл хөгжиж буй орнууд буюу хөгжсөн орнууд 20 мянгаас 50 мянган га дээр энэ өндөр технологийн паркийг барьж байгуулж байна. Бүр хөгжсөн орнууд бол 50-аас дээш мянган га дээр асуудал ярьж байна.

Тэгтэл бид 3 мянган га дээр арайхийн үйл ажиллагаа явуулах гэж байгаа паркийнхаа үйл ажиллагааг нэг хувийн хэвшил нь давамгайл байдал авчхаад ингээд явж байгаа асуудал бол үнэхээр эмгэнэлтэй байгаад байгаа юм.

Тэгээд 3 дугаарт тэр улсын өмч болгох гэдэг дээр бол санал нэг байна.

Тэгээд улс зоригтойгоор энд чинь 22 саяын хөрөнгө оруулалт хийж байгаа юман дээр одоо бодох юм бол 70 орчим тэрбум төгрөг. Тийм ээ. Тэгэхэд 791 сая төгрөгийг нь улс нэг удаа шийдээд энэ хүмүүсийг урдах ажлаа хийхэд нь анхаарлыг нь хандуулж болдоггүй юм уу гэсэн ийм санал байна. Баярлалаа.

Ч.Анар: Баярлалаа. Салбарын төлөөлөл компаниуд төрийн бус байгууллагуудын санал хүсэлтийг авч дууслаа.

Үг хэлэх Их Хурлын гишүүд нэрсээ өгье.

Буяагийн Тулга гишүүн үг хэлье. Дараа нь миний бие үг хэлнэ.

Б.Тулга: Эхний хэсэг яалт ч үгүй өмчийн маргаантай холбоотой асуудал боллоо гэж үзэж байна. Сонсголд ирсэн хувийн хэвшлийн төлөөлөл, төрийн бус байгууллагууд, төлөөллүүдийн үгийг сонслоо.

Тэгэхээр уг нь яг энэ асуудлыг л хэдүүлээ ялангуяа энэ Байнгын хороон дээр байнга ярьж байх ёстой гэдэг ийм бодолтой, ийм саналтай, ингэж санаа зовж байдаг хүний нэг.

Миний үндсэн мэргэжил ер нь хэрэглээний математикч, программист хүн байгаа. 25, 26 жилийн өмнө Монголын ирээдүйг их гоёор харж, анхны веб сайтыг бичиж байсан хүний хувьд анхаарал тавьж явдаг.

Гэхдээ харамсалтай нь улс төр хөөгөөд яг энэ салбар луугаа гүйцэд орж чадаагүй. Одоо тэгээд бас харьцангуй завтай болсон учраас Та бүхэнтэйгээ хамтран ажиллахад бэлэн байгаа гэдгийг юуны өмнө илэрхийлье.

Тэгээд энэ шаардлагатай мэдээллийн технологи, залуучууд гарааны компаниудыг дэмжих тал дээр харин одоо ёстой лобби групп. Манай Ч.Анар дарга байж байгаа. Манай энэ салбарын хэд хэдэн улсууд байж байгаа.

Хууль тогтоох түвшинд байж байгаа улсуудаа Та бүхэн минь тултал ашиглаарай. Та бүхний хэлж байгаа шүүмжлэлийг 100 хувь хүлээн зөвшөөрч байна. Өөрөөр хэлбэл маш олон хүн ярьдаг мөртлөө яг гар дээрээ хэрэгжүүлдэг, үүнийг гаргаж ирдэг хүн одоохондоо гараагүй байгаа.

Тэгээд Ч.Анар дарга Инновацын дэд хорооны дарга болоод бас удаагүй байгаа. Тийм ээ. Тийм.

Тэгэхээр энэ дэд хороо ч гэсэн өөрөө шинэ Их Хурлын ийм бүтцийн байгууллага.

Тэгэхээр Та бүхэнтэй илүү олон уулзаж энэ асуудлуудыг шийдэх байх гэж бодож байна.

Төрийн өмчийн хороонд нэг хүсэлт байна Төрийн өмчийн хороо энэ залуучуудын, энэ салбарын улсуудын хэлж байгаагаар Монголын ирээдүй, Монголын гэлтгүй бүс нутаг ирээд олон улсын ирээдүйн чиглэл юу вэ гэхээр мэдээллийн технологи. Энэ том өгөгдөл. Тийм ээ. Супер компьютер, хиймэл оюун ухаан гэж байгаа энэ үед ядаж энэ гарааных нь нөхцөл ажиллах амьдрах орчныг нь богино хугацаанд шийдэж өгөөч ээ. Ямар ямар гаргалгаа Та бүхэн гаргаж ирээч. Яг төсөв хүлээгээд явбал наадах чинь дахиад нэг, хоёр жилийн асуудал болно шүү.

Тэгэхээр төсөв дээр суулгаад тэрийг нь төлөөд гэдэг дахиад бүтэн жил алдана. Яагаад гэвэл өнгөрсөн оны төсөв суугаагүй учраас энэ бол шийдэгдэхгүй шүү.

Тийм учраас Та бүхэн энэ дээр маш тодорхой гаргалгааг Төрийн өмчийн хороо гаргаж яаралтай танилцуулах ийм чиглэлийг энэ Байнгын хороо өгөөсэй гэж бодож байна.

Тэгэхгүй хуулиараа шийдэгдэнэ гээд яваад байвал энэ бүтэхгүй ээ.

Тэгэхээр ямар өөр гарц гаргалгаа байна. Үүнийг Төрийн өмчийн хороо яаралтай гаргаж өг. Бусад бодлогын салбарын ажлаа манай Байнгын хороо Ч.Анар дарга маань ахлаад тодорхой хууль дүрэм журмуудыг гаргаад гарсан дүрэм журмуудыг хэрэгжүүлэх тал дээр онцгой анхаарч ажиллах байх.

Манай залуучууд сая хэлж байна. Киргиз хөрөнгө оруулаад бараг бид Киргизээс жишээ авах гэж яриад байдаг. Гэтэл IT-гийн салбарын улсууд мэдэж байгаа шүү дээ. Бид Киргизэд очиж ер нь шинэ технологи нэвтрүүлж байсан ийм улс шүү дээ. Уг нь. Бид Казакстан, Киргиз, энэ Төв Азийн манайхаас хойно ардчилал руу орсон гэдэг юм уу энэ улсуудад манайхан очиж түрүүлж зааж байсан улс. Харамсалтай нь өнөөдөр ингээд хоцрох нөхцөл ийм хурлын цэг дээр ирж байгаад аягүй харамсалтай байна.

Тэгэхээр энэ дээр Их Хурал дээр онцгой анхаарч ажиллах ёстой цаг үе иржээ.

Манай Ерөнхий сайд маань ч гэсэн өөрөө энэ салбарын инновац анхны цахим яамыг байгуулсан Байнгын хороог ахалж байсан ийм хүн Ерөнхий сайд болсон учраас яг энэ моментыг хэдүүлээ энэ цонхыг алдалгүй ашиглах нь бид нарын бидний өмнө тулгамдаж байгаа үүрэг болж байна шүү гэдгийг Та бүхэндээ байр сууриа илэрхийлмээр байна. Баярлалаа.

Ч.Анар: Баярлалаа.

Тэгэхээр юуны өмнө Мэдээлэл технологийн үндэсний паркийн захирал Ж.Золзаяад талархал илэрхийлье.

Яагаад вэ гэхээр энэ бол ганц IT Park-ийн өр төлбөрийн асуудал биш. Энэ бол монгол залуучуудын ирээдүйн итгэл, эх оронч сэтгэлгээ, бүтээмжийг хулгайлж байгаа асуудал.

Хоёрдугаарт, О.Батнайрамдал гишүүн, Б.Тулга гишүүний хэлж байгаагаар энэ бол асар олон өмчийн хулгайн зөвхөн нэг хэсэг нь байгаа байхгүй юу. Энэ бол хоёр том асуудлыг зоригтойгоор гаргаж ирж ярьж байгаа.

Тодорхой хэмжээнд Их Хурлын чиг үүрэгт байхгүй хэдий ч гэсэн энэ асуудлыг энэ Байнгын хороондоо авчирч байна.

Нэгдүгээрт, Их Хурлын зүгээс бол Их хурал хууль тогтоох, хууль тогтоолын хэрэгжилтэд хэрэгжилтийн энд хяналт тавих л чиг үүрэгтэй. Энэ хүрээндээ бид шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон Дээд шүүхийн шийдвэр гүйцэтгэлд оролцох ямар ч боломжгүй. Хуулийн хувьд боломжгүй.

Хоёрдугаарт, сая Б.Тулга гишүүний хэлж байгаа шиг 792 сая төгрөгийг бид шийдэх бололцоогүй ээ. Энэ бол Төрийн өмчийн хороо, Засгийн газар өөрийн чиг үүргийн хүрээндээ шийдэх ёстой асуудал.

Гэхдээ бид хэд боломжгүй гэж суухгүй ээ. Өнөөдөр гишүүд маань идэвхтэй оролцож энэ асуудлын дуу хоолой болж хойноос нь хөөцөлдөж явна.

Хоёрдугаарт, хуулийн хэрэгжилттэй холбоотой Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийн тухай хууль дээр түрүүн шүүмж явж байна. Энэ хууль маань дөнгөж ч хэрэгжиж эхлээд 2026 оны 01 сарын 01-нээс хэрэгжсэн. Энэ хуулийн үнэлэлт дүгнэлтийг гаргах хуулийн хугацаа нь болоогүй байгаа.

Бид энэ талаар Ж.Золжаргал гишүүн хуучин Байнгын хорооны дарга байхдаа 3 удаа хуралдсан. 2 удаа тогтоол гаргасан. Нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан төлөлтийн журмыг гарах гээд ажиллаж байна. Түүн дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд Т.Аубакир сайдтай ярилцсан. Тэр журмуудыг гаргахаар яг Их хурал чиг үүргээр ажиллаж байгаа.

Тэгэхээр бид нарын хувьд хамгийн эхний зүйл тэр нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох журмыг ажил хэрэг болгох ажил яг явж байгаа. 2 тогтоол гаргасан. Үүн дээр Ж.Золжаргал гишүүн миний бие болон бусад дэд хорооны гишүүд ажиллаж байгаа. Мэдээлэлд хүргэхэд.

Хоёрдугаарт, Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийн тухай хууль маань тухайн үеийн улс төрийн нөхцөл байдлаас болоод нэлээн учир дутагдалтай болсон.

Гэхдээ энэ хууль санаачлагчийн зүгээс биш улс төрийн нөхцөл байдлаас болсон. Одоо хуулийн хэрэгжилтийг нь үнэлэх хугацаа болоогүй байгаа нь бид нарт бас зовлон байгаа. Тийм асуудал байгаа гэдгийг Та бүхэнд хэлье. Үүн дээр бол бас яах вэ “МИТА” болон бусад төрийн бус байгууллагууд нийлээд шинэ санал боловсруулж байгаа

Гуравдугаарт, Мэдээлэл технологийн үндэсний паркийг статусыг нь өөрчлөх дээр Их Хурлын бүрэн эрхийн хэмжээнд боломжтой байгаа.

Тэгэхдээ энэ дээр тооцоо судалгаа сайн хийхгүй бол бас ямар үр дагавар гарах вэ гэдэг асуудал дээр Ж.Золзаяа захиралтай хамтраад ярилцаж байна.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны шинэ сайд Ч.Номин сайдаас санал ирүүлсэн байгаа. Үндэсний паркаас бас санал ирүүлсэн байгаа. Энэ дээр хамтарсан ажлын хэсэг гаргаад энэ асуудлыг шийдэхээр ажиллаж байгаа гэдгийг Та бүхэнд дуулгая.

Та бүхнээс хүсэх нэг зүйл байна. Энэ салбарын дуу хоолой болоод бодлого, шийдвэр гаргалтыг өөрчлөхөд бол Та бүхний дуу хоолой их хэрэгтэй байна. Энэ санал шүүмжүүд, зоригтой санал шүүмжүүд ил гараад ярих шаардлагатай байна. Бид нарын дуу хоолой маш сул байна. Энэ дотор гишүүд байдаг ч гэсэн энэ салбарын нөлөөлөл, ойлголтыг олгоно гэдэг маш хүнд ажил байна.

Тэгэхээр Та бүхэн зоригтойгоор дуу хоолойгоо ил тод нээлттэйгээр илэрхийлэх юм бол улс төр гэдэг нийгмээ л дагадаг.

Тэгэхээр салбарын маань онцлог өөрөө тийм. Ярьдаггүй, ил гардаггүй хүмүүс.

Тэгэхээр Та бүхэн ил гараад энэ салбарынхаа талаар санал шүүмжээ шийдвэр гаргагч, бодлого тодорхойлогч, ажил гүйцэтгэгч нарын төлөө зарчмын шаардлагуудаа гаргаж авах хэрэгтэй байна. Гомдоллож суух биш ажил ч хийх хэрэгтэй байна. Түүнийг Б.Тулга гишүүн болон бид хэд бол хоёр гараа өргөөд л дэмжээд л гүйгээд байгаа.

Тэгэхдээ Та бүхний дэмжлэг хэрэгтэй байгааг хэлье.

Тэгээд Монголынхоо ирээдүйг, залуучуудынхаа ирээдүйг дараа дараагийн удаа алдахгүй байх нь Та бидний хамтын итгэл, зүтгэлээс хамаарна гэдгийг хэлье.

Ингээд хүрэлцэн ирсэн Та бүхэнд баярлалаа.

Мэдээлэл технологийн үндэсний парк төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай холбоотой цаг үеийн асуудлаар мэдээлэлтэй танилцаж дууслаа.

Үүний дараагаар дэд хороо хуралдаж тухайн асуудлаар ямар санал, дүгнэлт гаргах вэ гэдэг асуудлыг хэлэлцэнэ.

Одоо бид бүхэн хуулийн хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон шүүхийн шийдвэр лүү нөлөөлөх тийм чиг үүрэг байхгүй гэдгийг дахин дуулгая. Баярлалаа. Та бүхэнд.

Хуралдаанд оролцсон ажлын хэсгийн гишүүд болон хүрэлцэн ирсэн байгууллагуудын төлөөлөлд баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 58 минут үргэлжилж, 15 цаг 46 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД